

ХАМТАРСАН БАГ



СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТАНД ЗОРИУЛСАН ГАРЫН АВЛАГА



ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ



ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



Нэмж засварласан 3 дахь хэвлэлт

© Хүүхдийг ивээх сан (2016, 2019)

© Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк (2023)

Боловсруулсан:

Б.Мөнхжаргал (2016, 2019)

Х.Өлзийтунгалаг (2023)

Хянан тохиолдуулсан:

Х.Өлзийтунгалаг

Г.Ойнбаяр

Э.Дуламсүрэн (2016, 2019)

Р.Нарантуяа ХНХЯ (2023)

Г.Амаржаргал ГХУСАЗЗАА (2023)

Гарын авлагын зургийг:

Г.Ганбаяр (2016, 2019, 2023)

Нэмж засварласан 3 дахь хэвлэлтийг Хууль зүй, дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банк хамтран "Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх" төслийн санхүүжилтээр хэвлэв.

Гарчиг

Шигтгээ, зураг, хүснэгтийн жагсаалт	4
ЖЕНДЭРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ БА ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ	5
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ХАМТАРСАН БАГТ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО	7
ХОЁРДУГААР БҮЛЭГ. ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ.....	11
2.1. Шуурхай тусламжийн үйлчилгээ	11
2.2. Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ.....	14
2.3. Урьдчилан сэргийлэх үйлчилгээ.....	31
ХАВСРАЛТ	33
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	41

ШИГТГЭЭ, ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Сургуулийн нийгмийн ажилтан	9
Зураг 2. Генограммын тэмдэглэгээ	19
Зураг 3. Экозураглалын тэмдэглэгээ	20
Хүснэгт 1. Хамтарсан багийн гүйцэтгэх үүрэг	7
Хүснэгт 2. Албан тушаалын тодорхойлолт	8
Хүснэгт 3. Эрсдэлийн үнэлгээ хийхэд анхаарах чиглэл	12
Хүснэгт 4. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх үе шат, анхаарах зүйлс	22
Хүснэгт 5. Хамтарсан багаар үзүүлэх холбон зуучлах үйлчилгээ	23
Хүснэгт 6. Холбон зуучлах үйлчилгээнд анхаарах асуудал.....	24
Хүснэгт 7. Хохирсон хүүхдийн эрх ба түүнийг хамгаалах.....	26
Хүснэгт 8. Хүүхдийн эрх зөрчигдсөн тохиолдолд хамгаалах хуулийн зохицуулалт	27
Хүснэгт 9. Сургуульд түшиглэсэн хөтөлбөрүүд.....	32
Шигтгээ 1. Боловсролын тухай хуулиас	8

ЖЕНДЕРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ

“ЖЕНДЕРТ СУУРИЛСАН ХҮЧИРХИЙЛЭЛ” гэж жендэрээс үүдэлтэйгээр бусдад бие махбодын, бэлгийн, сэтгэл санааны гэм хор, эдийн хохирол учруулсан, учруулж болзошгүй үйлдэл эс эс үйлдэхүйг хэлнэ.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулиас

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод хандсан үйлдэл, эс үйлдэхүйг хэлнэ.

БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүнийг өөрийн эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ.

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ

Биеийг нь үнэлүүлэх бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах. Эд эрхтнийг авах албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлах, хууран мэхлэх итгэл эвдэж. Эрх мэдлээ урвуулан ашиглаж эмзэг байдлыг нь дамжуулж эсхүл бол хяналтдаа байлгаж байгаа хүн төлбөр төлж, хахуульдаж, хүнийг эрхшээлдээ оруулан Элсүүлсэн, тээвэрлэсэн, орогнуулсан, дамжуулсан, хүлээн авсан үйлдлийг хэлнэ.

АЖЛЫН БАЙРНЫ БЭЛГИЙН ДАРАМТ

Бусдыг хүсээгүй байхад нь бэлгийн сэдлээ үг хэлээр биеэр буюу өөр хэлбэрээр илэрхийлсэн. Эс л бол харьцал үйлдэхээс аргагүй байдалд оруулсан. Мөн бэлгийн сэдлийн улмаас ажил, албан тушаал, эд материал, сэтгэл санааны болон бусад байдлаар хохироох үр дагавар бүхий тэвчишгүй Орчин үүсгэх, айлган сүрдүүлэх, тулган шаардах зэрэг үйлдэл эс үйлдэхүйг эсхүл бэлгийн сэдэлтэй аливаа үйлдлийг давуу эрх Болгож эдлүүлэх болзол болгон тавихыг хэлнэ.

ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

1. БИЕ МАХБОДЫН ХҮЧИРХИЙЛЭЛ

гэр бүлийн хамаарал бүхий хүний амь нас эрүүл мэндэд гэм хор учруулсан эсхүл учруулж болзошгүй аливаа үйлдлээс үйлдэхүй хэлнэ.

2. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний эрхшээлтэй байгаа байдлыг далимдуулан энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүнийг бэлгийн шинжтэй аливаа үйлдэлд албадахыг хэлнэ.

3. СЭТГЭЛ САНААНЫ ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний хүсэл зоригийн эсрэг тодорхой үйлдэл хийх эсхүл хийхгүй байхыг албадан албадах. Үл хайхрах, гүтгэх, мөрдөн мөшгөх, заналхийлэх, бусадтай харилцахыг хязгаарлах, гутаан доромжлох болон бусад хэлбэрээр сэтгэл санааны шаналал үүсгэснийг

4. ЭДИЙН ЗАСГИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ

Гэр бүлийн хамаарал бүхий хүний цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээрийн адилтгах орлого, хуваарьт болон дундын эд хөрөнгө. Эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдах оролд. Орлого олох боломжийг нь хязгаарлах шаардлагатай хэрэгцээг нь хясан боогдуулах. Тэжээн тэтгэхээс зайлсхийх болон бусад хэлбэрээр эдийн засгийн хараат байдалд оруулсан эсхүл бол эд хөрөнгийн хохирол учруулсныг хэлнэ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

СУРГУУЛИЙН НИЙГМИЙН АЖИЛТНЫ ХАМТАРСАН БАГТ ГҮЙЦЭТГЭХ ҮҮРЭГ, ОРОЛЦОО

Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжтой нийцэж гарсан дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана. Хамтарсан баг нь Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай болон Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засаг даргаар ахлуулсан зохион байгуулалтын хэлбэр бөгөөд гэр бүл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрт шатад илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг нөхөн сэргээхэд чиглэсэн цогц үйлчилгээг үзүүлнэ.

Хүснэгт 1. Хамтарсан багийн гүйцэтгэх үүрэг

Хамтарсан багийн үүрэг	
Хуулиар хүлээсэн чиг үүрэг	Үүргийн хэрэгжилтийг хангах арга зам
Эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 20.2.2)	Үнэн зөв, бодитой мэдээлэл, судалгааны сан бүрдүүлэх, ашиглах, төлөвлөх, хэрэгжүүлэх Нөхцөл байдлын үнэлгээнд дүн шинжилгээ хийх, үйлчилгээг зохион байгуулах Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, ажлыг зохион байгуулах Дэмжин туслах, холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх Үйлчилгээний үр дүн, үр нөлөөг тооцох
Үйлчилгээг төлөвлөн хэрэгжүүлэх (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 20.2.3)	
Хохирогчийг хамгаалах, нөхөн сэргээх, ажлыг зохион байгуулах (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 20.2.4)	
Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, нийгмийн эрүүл мэндийн үйлчилгээнд хамруулах, гэр бүлд нь дэмжлэг үзүүлэх замаар нөхөн сэргээж, нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 20.2.5)	
Үйлчилгээний талаарх статистик мэдээллийг холбогдох байгууллагад хүргүүлэх (Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, 20.2.6)	

Хүүхэд хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, дээрэлхэх, үл хайхрах байдалд өртөх эрсдэлтэй байхаас гадна заримдаанас, хүйс, угсаа гарал, үндэсний цөөнх, хөгжлийн бэрхшээл, нийгмийн байдал зэргээс шалтгаалан эрсдэл, эмзэг байдал нь нэмэгддэг байна. Иймээс хүүхэд хамгааллын үйлчилгээ хүүхдэд чиглэгдсэн байх, ялангуяа илүү өндөр эрсдэлд байгаа хүүхдийн онцлог хэрэгцээг харгалзан, тэдэнд чиглэгдсэн цогц, тусгай үйл ажиллагаа байна.

Хүүхдийн эсрэг хүчирхийллийг юугаар ч зөвтгөж болохгүй. Хүчирхийллийн бүх хэлбэрээс урьдчилан

Мэдээллийн санбар
Багш нь суралцагчийн бие мэхбөдөд
халцах, тэдэнд сэтгэл санааны
дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь
задруулахыг хориглоно.
Монгол Улсын Боловсролын
тухай хуулийн 44.3



сэргийлж болно. НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенц (ХЭК)-ийн дагуу хүүхэд бүр бүх төрлийн хүчирхийллээс хамгаалуулах эрхтэй. Хүүхэд гэр бүлдээ, сургууль дээрээ, халамж асрамжийн төвд, гудамж талбайд, хэвлэл мэдээллийн бүхий л орчинд хүчирхийлэл, дарамт, дээрэлхэх үзэгдэлд өртөж байна. Иймээс хүүхэд хамгааллын үйлчилгээг хамтарсан багаар үзүүлэх нь хүүхэд түүний гэр бүлд цогц үйлчилгээг үзүүлж, асуудлыг олон талаас харж, оролцож, шийдвэрлэхэд ач холбогдолтой болно.

Монгол Улс хүүхдийн эсрэг хүчирхийлэл, шийтгэлийг бүх орчинд хуулиар хориглосон. Боловсролын орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, шийтгэлийг 2006 онд Боловсролын тухай хуульд нэмэлт оруулж хуульчилсан. Хэдий тийм боловч багш нь хүмүүжүүлэх нэрийн дор хүүхдэд бие махбодын шийтгэл болон сэтгэл санааны дарамт үзүүлэх явдал байсаар байна. Энэхүү харилцааг зохицуулах, хүчирхийлэл дарамтад өртсөн хүүхдийг хамгаалахад сургуулийн нийгмийн ажилтан чухал үүрэгтэй.

Шигтгээ 1. Боловсролын тухай хуулиас

Багш нь суралцагчийн бие махбодод халдах, тэдэнд сэтгэл санааны дарамт үзүүлэх, хувийн нууцыг нь задруулахыг хориглоно¹.

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нь цогц байх хэрэгтэй. Цогц гэдэг нь хүүхдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, дээрэлхэх, үл хайхрах байдалд өртөхөөс урьдчилан сэргийлж, олон нийтийн ойлголт хандлагыг сайжруулах үйл ажиллагааг тогтмол явуулдаг, хэрэв хүүхэд эрсдэлд өртвөл хамгаалах, нөхөн сэргээх, үйлчилгээ үзүүлдэг, тухайн үйлчилгээг зохих стандарт шаардлага, дүрэм журмын дагуу хүргэхдээ хамтарсан багаар ажиллаж, хүүхдэд аюулгүй орчинд өсөх боломжийг олгох олон талт үйл ажиллагаа юм. Нэг хүүхдэд тулгарч буй асуудал нь олон учир шалтгаантай, тухайн асуудлыг шийдэхэд олон салбарын, ялгаатай үйлчилгээнүүд шаардагддаг учир хүүхэд хамгааллын үйл ажиллагаанд салбар хоорондын уялдаа холбоо чухал юм.

Сургуулийн нийгмийн ажлын үйлчилгээ гэдэг нь хүүхдийг хүчирхийлэл, дарамт, шийтгэл, дээрэлхэх үзэгдэл, ялгаварлал, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, хохирсон эрхийг нь нөхөн сэргээх, чадваржуулах, нийгэм-сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, амьдралд нь нөлөөлж буй хүрээлэн байгаа орчин, хүмүүсийн харилцааг сайжруулах, холбогдох байгууллага, үйлчилгээнд зуучлах, мэдээлэх мэргэжлийн үйл ажиллагаа юм.

Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны ажлын байрны тодорхойлолт, үйл ажиллагааны нийтлэг жишиг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2020 оны Б/03 дугаар тушаалаар батлагдсан.

Хүснэгт 2. Албан тушаалын тодорхойлолт

Албан тушаалын зорилго:	Албан тушаалын зорилт:
Боловсролын салбарын болон хүүхэд хөгжил, хамгааллын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг сургуулийн хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах, үнэлэх ажлыг удирдан зохион байгуулна.	1.Боловсролын салбарын болон хүүхэд хөгжил, хамгааллын бодлого, хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг сургуулийн хэмжээнд төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах; 2.Хүүхдийн эрх, хамгаалал, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх; 3.Хүүхдийн хөгжил, төлөвшил, сонирхол хэрэгцээнд тулгуурлан хичээлээс гадуурх сургалтын ажлыг төлөвлөх, удирдлага арга зүйгээр хангах;

¹ Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 44.3

Сургуулийн нийгмийн ажилтан гэж суралцагч, эцэг эх болон багшийн харилцаа, тэдний нийгмийн асуудлаар үнэлгээ хийх, ганцаарчилсан болон бүлэгт чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө өгөх замаар нийгмийн сөрөг үзэгдлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх, тэдний төлөвшил, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлдэг мэргэжилтнийг хэлнэ.

Зураг 1. Сургуулийн нийгмийн ажилтан



Сургуулийн нийгмийн ажилтан Боловсролын тухай хуульд зааснаас гадна гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хамтарсан багийн гишүүний хувиар дараах үүргийг хүлээнэ². Үүнд:

- гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх чиглэлээр хамтарсан багтай хамтран ажиллах;
- гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, туслалцаа, дэмжлэгийн талаар эцэг, эх, багш, холбогдох бусад ажилтанд зөвлөгөө өгөх;
- гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагч, багш, боловсролын байгууллагын бусад ажилтан, эцэг, эхэд мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 14.1.1, 14.1.2-т заасан хөтөлбөр, стандарт, журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.

Хамтарсан багийн гишүүний хувьд сургуулийн нийгмийн ажилтан хүүхэд хамгааллын үйлчилгээг дараах зорилтот бүлэгт хүргэнэ. Үүнд:

- Хүчирхийлэлд өртсөн хүүхэд,
- Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, гэрч хүүхэд,
- Хүчирхийлэл үйлдэгч төрлийн зан төлөвтэй, бэлгийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй эрсдэл бүхий хүмүүстэй амьдарч буй хүүхэд,
- Интернэт/ цахим орчинд хүчирхийлэлд өртөж болзошгүй хүүхэд,
- Зан үйлийн өөрчлөлттэй, өөртөө хохирол учруулах, амиа хорлох сэдэл гаргаж байсан хүүхэд,
- Гэрээсээ дайжсан хүүхэд,
- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд,
- Сэтгэцийн эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай хүүхэд,
- Орон гэргүй хүүхэд,

² Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26 дугаар зүйл, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017

- Хүн худалдаалах гэмт хэрэгт болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхэд,
- Асрамж халамжийн төвд байдаг хүүхэд
- Хөгжлийн бэрхшээлтэй эцэг эхтэй хүүхэд
- Сэтгэцийн өвчтэй эцэг эхтэй хүүхэд,
- Архи болон мансуурах бодисын хамааралтай эцэг эхтэй хүүхэд,
- Насанд хүрээгүй эцэг эх болсон хүүхэд
- Өсвөр насны жирэмсэн охид

Боловсролын байгууллагын орчинд хүүхдийг хамгаалах үүргийг багш, сургуулийн нийгмийн ажилтан, сургуулийн удирдлага, ажиллагсад хүлээж, хүчирхийлэл, дарамт, дээрэлхэлт, мөлжлөг, үл хайхрах байдлаас урьдчилан сэргийлж, хүүхдийн хамгаалагдах эрх зөрчигдсэн тохиолдолд үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ёстой. Урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хүүхдийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийллийг илрүүлэх, мэдээлэх, хамтран ажиллах үйл ажиллагааг ч мөн хариуцна.

Тиймээс сургуулийн нийгмийн ажилтан нь багш, сурган хүмүүжүүлэгч, эцэг эхчүүдэд хүүхдийн эрхэд суурилсан аргагүй, хүүхэд хамгаалал, хүмүүжлийн эерэг арга гэх мэт хүүхдийн хөгжил, төлөвшил хүмүүжилд үр дүнтэйгээр нөлөөлөх сургалтуудыг зохион байгуулж, олон нийтийн хандлага, ойлголт, мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх ажлыг гүйцэтгэж байх үүрэгтэй.

ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ

2.1.ШУУРХАЙ ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Шуурхай тусламжийн үйлчилгээ нь хүчирхийлэл, дарамтад өртсөн хүүхдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж, тухайн хүүхдийн аюулгүй байдал, хүчирхийлэл дарамтыг үүсгэж буй эрсдэл, хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлыг үнэлэхээс эхэлдэг. Хүүхэд хүчирхийлэл, дарамтад өртсөн, гэмтэж бэртсэн, аюултай нөхцөлд байгаа нь илэрвэл сургуулийн нийгмийн ажилтан хамтарсан багийн бусад гишүүдийн тусламжтайгаар хүүхэд, гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах яаралтай, шуурхай арга хэмжээ авна.

Хүүхэд хамгааллын шуурхай, тусламжийн үйлчилгээнд дараах үйлчилгээнүүд багтана:

- Хүүхэд аюултай нөхцөл байдалд байгаа тухай шуурхай болон тусгай дугаарын утсанд ирсэн хяналт болон шуурхай дуудлагын үед аюулын зэргийг тогтоох, эрсдэлийн үнэлгээг хийх дуудлага авснаас хойш 24 цагийн дотор үнэлгээ хийнэ.
- Нөхцөл байдлын үнэлгээг 72 цагийн дотор хийнэ.
- Эрсдэлийн түвшнээр аюулын түвшин бага гэж тогтоогдсон тохиолдолд нөхцөл байдлын үнэлгээг гурваас тав хүртэлх өдрийн дотор хийнэ.
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн, амь нас, эрүүл мэнд аюултай нөхцөл байдалд байгааг тогтоох эрсдэлийн болон аюулгүй зэргийн үнэлгээгээр илэрсэн бэртэл, гэмтлийг яаралтай эмчлэх шаардлагатай тохиолдолд дараах мэргэжлийн байгууллагын шуурхай тусламжид үзүүлнэ:
 - Эмнэлгийн шуурхай тусламж,
 - Хууль эрх зүйн шуурхай тусламж,
 - Нийгмийн ажлын шуурхай үйлчилгээ,
 - Сэтгэл зүйн зөвлөгөө, сэтгэл заслын үйлчилгээ.
- Эрсдэлийн үнэлгээний үед аюулын зэргийн түвшин бага гэж үзэн хүүхдийг гэрээс нь эсхүл амьдарч буй газраас тусгаарлан авч явахгүй үлдээх тохиолдолд хүүхдийг хүчирхийлэлд дахин өртөхөөс хамгаалах аюулгүйн төлөвлөгөөг хүүхэд, хүүхдийг хамгаалж чадах эцэг, эх асран хамгаалагчтай хамтран боловсруулах, хэрэгжүүлэх заавар, зөвлөгөөг өгнө.
- Эрсдэлийн үнэлгээний үед хүүхэд хүчирхийлэлд дахин өртөх, амь насанд аюултай байх эрсдэлтэй хүүхдийг түр байрлуулах, нэг цэгийн үйлчилгээ, түр хамгаалах байранд хүргэж өгнө.



Хүснэгт 3. Эрсдэлийн үнэлгээ хийхэд анхаарах чиглэл

	1-р түвшин	2-р түвшин	3-р түвшин	4-р түвшин
Хор хөнөөлийн төрөл	Хүүхдэд маш хор хөнөөлтэй, яаралтай шуурхай үйлчилгээ хүргэх шаардлагатай (24 цагийн дотор хариу үйлчилгээ санал болгох, 7 хоног бүр үйлчилгээ хүргэх)	Хүүхдэд хор хөнөөлтэй, үйл явцын дагуу хариу үйлчилгээ хүргэх шаардлагатай (3 хоногийн дотор хариу үйлчилгээ санал болгох, 7 хоног бүр үйлчилгээ хүргэх)	Хүүхэд хор хөнөөлд өртөх эрсдэлтэй, хяналт үнэлгээ шаардлагатай (7 хоногийн дотор хариу үйлчилгээ санал болгох, 1 - 30 хоног үйлчилгээ хүргэх)	Хүүхэд эрсдэлгүй, цаашид үйлчилгээ, үйл ажиллагаа авч хэрэгжүүлэх шаардлагагүй, кейсийг хаасан (шаардлагатай бол шинэ холбон зуучлах үйлчилгээнд хяналт үнэлгээ хийхэд анхаарах)
Хүчирхийлэл (бие махбодын)	Нярай, бага насны хүүхдийн ноцтой гэмтэл Хүүхдийн амиа хорлох оролдлого	Бие махбодын шийтгэл Зүсэгдсэн шарх сорви Аюултай, анхаарал төвлөрөхгүй зан төлөв Өөрийгөө гэмтээх	Зүсэгдсэн шарх сорви Үе үе бие махбодын шийтгэлд өртөх	Одоогийн нөхцөлд дарамт, хүчирхийлэл байхгүй (хор хөнөөл учруулах хүчин зүйлс байхгүй болсон) Буруутай этгээд хүүхэдтэй холбоогүй болсон
Хүчирхийлэл (бэлгийн, сэтгэл санааны)	Насанд хүрээгүй хүүхэдтэй бэлгийн харилцаанд орох (хүүхдэд хор хөнөөл учруулах) хүүхэд дорд үзэгдэх, тусгаарлагдах	Хүүхэдтэй гэрлэнэ гэж амлах, өмнө бэлгийн дарамтад өртсөн боловч тусламж аваагүй байх, хүүхдийг хор хөнөөлтэй гэж үзэх	Хүүхдэд ах эгч, дүүгээс нь өөрөөр хандах, эцэг эх нь хүүхэдтэй сөрөг хандах	Хүүхэд гэр бүл туслалцаа авсан, одоо бэлгийн дарамтад өртөхгүй, сэтгэлзүйн хувьд тайван байгаа (эцэг эхэд дэмжлэг үзүүлэх) Буруутай этгээд хүүхэдтэй холбоогүй болсон
Үл хайхрах	Үл хайхрагдсанаас өвдөх юм уу гэмтсэн (хоол тэжээлийн дутагдалд орсон)	Анхаарал халамж дутагдах, суурь хэрэгцээнд анхаарал хандуулахгүй байх, хамгаалахгүй байх, харах хүнгүй орхих, хөгжилд нь анхаарахгүй байх	Асран хамгаалагчид сэтгэлзүйн хувьд хол хөндий харилцаатай байх	Хүүхдийн суурь хэрэгцээг хангаж байгаа
Мөлжлөг	Хүүхдийг аюултай нөхцөлд олон цагаар ажиллуулах	Бага насны хүүхдийг олон цагаар ажиллуулах	Эцэг эх нь хүүхдийг ажил хийхийг албадах	Хүүхэд хөдөлмөр эрхлэхээ больсон
Нийгэм-сэтгэлзүйн бэрхшээл (эцэг эхийн зүгээс даван туулах буюу хамгаалахад оролцохгүй эсвэл ямар нэг үйлчилгээ аваагүй)	Хүүхдийн амиа хорлох оролдлого Эрсдэлтэй зан үйл гаргах Бусадтай харилцааа болих Бодит байдлын мэдрэмж нь ярихад илрэх Хүчирхийллийн зан авир илрэх	Хүүхдийн нийгмийн ур чадвар, өөртөө анхаарал хандуулах, сургуульд явах нь багассан Архи, тамхи хэрэглэх Сэтгэх чадваргүй болох Орондоо шээх Ихэнх үед уйлах буюу гуниглах Гэнэт, хүчтэй айдас түгшүүртэй болох Унтах, анхаарал төвлөрөхөд хэцүү байх Наснаасаа хамаагүй бага юм шиг аашлах Өөрийгөө гэмтээх	Гунигтай, зожиг болох Уур уцаартай болох	Хүүхдийн нийгэм-сэтгэлзүйн байдал сайжирч байгаа Хүүхэд төрөл бүрийн үйл ажиллагаанд оролцож, үүнд сэтгэл санааны хувьд тайван ханддаг болсон.

Хараа хяналтгүй хүүхэд	5-аас доош насны хүүхэд харгалзах хүнгүй явах 5-аас доош насны хүүхэд гэр бүлээсээ тусдаа амьдарч байгаа	12-аас доош насны хүүхэд харгалзах хүнгүй явах 12-аас доош насны хүүхэд гэр бүлээсээ тусдаа амьдарч байгаа Өрх толгойлсон хүүхэд	Хараа хяналтгүй хүүхдэд асран хамгаалагч томилж, суурь хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа	Хүүхдэд зохих ёсоор анхаарал халамж тавьдаг, үйл ажиллагаанд хэдэн 7 хоногийн турш үнэлгээ хийхэд үүссэн асуудал байхгүй
Өсвөр насны жирэмслэлт	Хараа хяналтгүй өсвөр насны хүүхэд жирэмсэн болох буюу эцэг эх болох	Сэтгэлзүйн хувьд өвчлөлтэй, хөгжлийн бэрхшээлтэй, гэр бүл нь эсэргүүцэж буй, дэмждэггүй өсвөр насны хүүхэд жирэмсэн болох буюу эцэг эх болох	Өсвөр насны хүүхэд жирэмсэн болох буюу эцэг эх болсон боловч гэр бүл нь дэмжлэг үзүүлдэг.	Өсвөр насны хүүхэд жирэмсэн болох буюу эцэг эх болсон боловч гэр бүл болон дэмжлэгийн сүлжээ маш сайн дэмжлэг үзүүлдэг
Хөгжлийн бэрхшээл, архаг хууч өвчин	5-аас доош насны хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, тэдний гэр бүл зохих дэмжлэг тусламж авч чадахгүй байх	Хөгжлийн бэрхшээлтэй, архаг хууч өвчтэй, зан төлөвийн хувьд биеэ хянаж авч явж чаддаггүй хүүхэд	Хөгжлийн бэрхшээлтэй, архаг хууч өвчтэй боловч зохих дэмжлэг тусламж авдаг, гэр бүл нь маш сайн дэмжлэг үзүүлдэг
Гэр бүлийн хүчирхийлэл	5-аас доош насны хүүхэд дарамт хүчирхийлэлд өртсөн 5-аас доош насны хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн гэрч болсон Гэр бүлийн хүчирхийллээс шалтгаалж хүүхдийн эцэг эх хүнд гэмтэх	Хүүхэд, гэр бүл шаардлагатай тусламж дэмжлэг авч чадахгүй байх Хүүхэд суралцах, нийгэмших бэрхшээлтэй эсвэл сэтгэлзүйн хувьд хямралтай байх	15-аас дээш насны хүүхэд хэд хэдэн дарамт хүчирхийлэлд өртөж байснаас шалтгаалан дэмжлэгийн сүлжээнд харьяалагддаг	Одоо дарамт хүчирхийлэлтэй харилцаа байхгүй (шаардлагатай үйлчилгээнд хамрагдсан) Буруутай этгээд хүүхэдтэй холбоогүй болсон

Сургуулийн нийгмийн ажилтан шуурхай тусламжийн үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд:

- “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын дагуу санхүүжилт авах эрхтэй.
- Шуурхай тусламжийн үйлчилгээний зардлын бүрэлдэхүүнд нөхцөл байдлын үнэлгээ хийх, шаардлагатай тохиолдолд кейс нээхэд шаардагдах бичиг хэргийн зардал, баримтжуулах, холбон зуучлах, хүүхэд хамгааллын үйлчилгээний багцын болон тээврийн зардал, хамгаалах хэрэгсэл, түүнчлэн Хүүхэд хамгааллын хуулийн 12.6-д заасан урамшуулал багтана.
- Сургуулийн нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийсэн тоог хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын нэгдүгээр хавсралтад шуурхай тусламж, үйлчилгээний нормативаар үржүүлж тооцно.

2.2. ХАМГААЛАХ, НӨХӨН СЭРГЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Ерөнхий боловсролын сургуулийн хүүхэд хүчирхийлэлд өртсөн нь тогтоогдвол:

- тухайн хүүхдийг эрсдэлт байдал тогтворжих хүртэлх хугацаанд аюулгүй байдлыг хангах, үргэлжлүүлэн сургах ажлыг зохион байгуулах,
- тухайн сургуульд суралцахад эрсдэлтэй нөхцөл байгаа бол түр хамгаалах байрны хамгийн ойр байршилтай сургуульд түр шилжүүлэн сургах,
- сургууль байхгүй бол сургалт зохион байгуулах эрх бүхий төр, төрийн бус байгууллагад түр шилжүүлэн сургах,
- сургууль завсардсан бол боловсролын дүйцсэн хөтөлбөрт хамруулах, эсхүл насан туршийн боловсролын төвийг түшиглэн сургалт зохион байгуулахыг сургууль хариуцна.³

Мөн:

- хүчирхийлэлд өртсөн болон болзошгүй эрсдэлт байгаа насанд хүрээгүй хүүхдийн боловсролын эзэмшсэн байдалд үнэлгээ хийх,
- хүүхдийн боловсролын баримт бичгийг үндэслэн суралцах түвшин, анги хэлбэрийг тодорхойлох,
- хүүхдийн боловсролын баримт бичгийг хянах, зөрчлийг арилгах, нөхөн олгох, сургалт зохион байгуулахад шаардагдах ном сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүн дүрэмт хувцсаар хангах зэрэг нэмэгдэл зардлыг тухайн боловсролын байгууллагын төсөвт нэмж олгох асуудлыг "Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай" хуулийн 19.1.5 дах заалтыг үндэслэн уламжлан шийдвэрлүүлж, тайлагнахаар тусгагджээ.

Иймд хүчирхийлэлд өртсөн хүүхэд аль ч хэлбэрийн сургалтаар суурь боловсрол нөхөж байх үед хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, боловсролын үйлчилгээнд тасралтгүй хамруулахад сургуулийн нийгмийн ажилтан аймаг, нийслэл, сум дүүргийн Боловсролын газар, хэлтэс, Насан туршийн боловсролын төв, ерөнхий боловсролын сургуулиудтай хамтран ажиллах шаардлагатай.

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь ороход нь туслах нөхөн сэргээх үйлчилгээг хүүхэд, түүний гэр бүлд нөлөөлөх хүүхдийн эсрэг хүчирхийллийн эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсээс хамаарч гэр бүлийн орчинд эсхүл гэр бүлээс орчноос тусад нь хүргэнэ. Үүнд:

- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлийн орчинд нь хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хүүхэд, түүнийг гэр бүлд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээ, явуулын үйлчилгээ, сэтгэл зүйн засал, эмчилгээ зэрэг шууд үзүүлэх үйлчилгээнээс гадна бусад салбарын үйлчилгээ багтана.
- Гэр бүлд суурилсан хамгааллын үйлчилгээнд хүүхэд, гэр бүлийн гишүүдийн амьдралын үечлэл, хөгжлийн, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх гэсэн олон талт үйлчилгээг хамруулдаг.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг хамгаалах, эргэн хэвийн амьдралд нь ороход нь туслах нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлнэ.
- Хүүхдийг мэдээллээр хангах, дэмжин урамшуулах, зан үйлийг өөрчлөх, сэтгэлзүйн цочрол, гэмтлээ даван туулахад туслах нийгэм-сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх, кейс менежментийн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, орлого нэмэгдүүлэх,

³ Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2018 оны А/612 дугаар тушаал

эргэн нийгэмшүүлэх үйлчилгээ үзүүлнэ.

- Хүүхэд, түүний гэр бүлд нөлөөлөх, хүчирхийллийн эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсээс хамаарч гэр бүлийн орчинд эсхүл гэр бүлээс орчноос тусад нь хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээг хүргэнэ.
- Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг гэр бүлийн орчинд нь хамгаалах нөхөн сэргээх үйлчилгээнд хүүхэд, түүнийг гэр бүлд чиглэсэн үйлчилгээ үзүүлнэ.
- Хүүхдийн бие махбодын гэмтэл, сэтгэцийн хамгаалах, нөхөн сэргээх эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлнэ.
- Эцэг эх хүүхдээ хамгаалах, хүмүүжлийн эерэг аргад суралцахад нь туслах, гэр бүлийн харилцаа холбоог сайжруулах, гэр бүлийн болон гэр бүлийн гишүүдэд тулгарсан хямралыг даван туулахад нь туслах, гэр бүлийн албан ба албан бус туслах дэмжих тогтолцоог бэхжүүлэхэд туслах үйлчилгээг үзүүлнэ.
- Гэр бүлээс тусад нь хүүхдийг хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлнэ:
 - Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ,
 - Нэг цэгийн үйлчилгээ- түр хамгаалан байрлуулах,
 - Төвлөрсөн асрамжийн үйлчилгээ,
 - Халамжийн хувилбарт үйлчилгээ (асралт гэр бүл, садан төрлийн асрамж),
 - Гэр бүлд нь эргэн нэгтгэх үйлчилгээ зэрэг үйлчилгээ хамаарна.

Кейс менежментийн үйлчилгээ

Хүүхдийн эсрэг хүчирхийллийн тодорхой нэг тохиолдлыг хариуцан ажиллаж буй сургуулийн нийгмийн ажилтан нь дангаараа буюу хамтарсан багийн гишүүд, бусад мэргэжилтэнтэй хамтран хүчирхийлэлд өртсөн хүүхдийг илрүүлэх, хүүхэд, түүний гэр бүлийн нөхцөл байдлыг судлах, тухайн хүүхэд, гэр бүлтэй ажиллах төлөвлөгөө гаргах, төлөвлөгөөний дагуу хамгааллын үйлчилгээ хүргэх эсхүл үйлчилгээ үзүүлэх буй байгууллага мэргэжилтнүүдтэй холбох, тэдний уялдаа холбоог зохицуулах, хянах, үнэлэх, хаах үйл явц бүхий кейс менежментийн үйлчилгээг дараах үе шат, үйл явцаар хүргэнэ.

Нэг. Харилцаа холбоо тогтоох /илрүүлэх

Хүүхэдтэй ажиллах анхны гараа бол харилцан бие биеэ ойлгох, итгэлцэл үүсэх ба хамтран ажиллах, үйлчлүүлэгч хүүхэд, гэр бүл тухайн байгууллагаас үйлчилгээг авах итгэлцэл бий болоход чиглэгддэг.

- Хүүхэд эмзэг байдлын шалгуурыг хангаж байгаа эсэхийг тодорхойлж, эмзэг байдлын шалгуур хангаж байвал хүүхэд болон асран хамгаалагчийн зөвшөөрлийг авч үндсэн суурь мэдээллийг баримтжуулна.
- Хүүхдийн/кейс бүртгэлийн давхардлаас сэргийлэхийн тулд кейс менежментийн үйлчилгээ авч байгаа хүүхдэд тусгай бүртгэлийн дугаар өгнө.
- Хүүхдийн /кейсийг бүртгэж, үйлчилгээ эхэлснээс хойш уулзалт бүрт үйл явцын тэмдэглэл хөтөлнө.
- Илрүүлэлтийн дараа хүүхдийг тухайн орон нутагт байгаа гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, эсвэл хариуцсан мэргэжилтэн, ажилтанд мэдэгдэнэ.

- Хүүхдээс ярилцлага авах, бичиг баримт бүрдүүлэх, мэдээллийг нь бусад үйлчилгээ үзүүлэгчтэй хуваалцахдаа хүүхдийн зөвшөөрлийг авч ажиллана.

Хоёр. Нөхцөл байдлын үнэлгээ хийх

Нийгмийн ажилтан хүүхэд, гэр бүлийн тулгарч буй асуудлын шалтгаан нөхцөл байдалтай холбоотой бүх мэдээллийг цуглуулах, хүүхдийн сэтгэцийн хөгжилд үнэлгээ хийснээр асуудал бэрхшээлийг эрт илрүүлэх, хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, тусламж дэмжлэгийг төлөвлөх, асуудал бэрхшээл хүндэрч ноцтой болохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой.

Хүүхдийн үнэлгээнд дараах асуудлыг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Хүүхдийн үнэлгээ нь гэр бүлийн орчин, гэр бүлийн соёлыг ойлгох, эцэг эхээс хүүхдийн талаар мэдээлэл авах, хүүхдийн ар гэрийн орчин, нөхцөлтэй танилцахыг шаарддаг. Хүүхдийн хүрээлж буй орчны үнэлгээ нь үнэлгээний салшгүй хэсэг юм.
- Хүүхдийн үнэлгээ нь мэдээлэл цуглуулах уян хатан ажилбарыг шаарддаг. Үнэлгээ хийгдэх хоногийн хэсэг, хүүхдийн эрүүл мэндийн байдал, оношилгоо үнэлгээний материал, нөхцөл байдлын бусад хүчин зүйл хүүхдийн ажиллах чадварт нөлөөлдөг. Хүүхдийн нас бага байх тусам нойрмоглох, ундууцах, зааварчилгааг биелүүлэхээс татгалзах, анхаарал нь сарних магадлал ихтэй. Үнэлгээ хийж байгаа нийгмийн ажилтан үнэлгээний үр дүнг гажуудуулах буруу зөрүү мэдээлэл цуглуулах эрсдэлээс зайлсхийх үүднээс үйл ажиллагааны хэлбэрийг өөрчлөх, хувилбарт ажилбарт шилжих эсвэл үнэлгээ хийх хугацааг хойшлуулахад бэлтгэлтэй байх хэрэгтэй.
- Хүүхдүүд бодит практик үйлдлээр дамжуулж суралцдаг бөгөөд тэд бодит практик үйлдлийн тусламжтайгаар өөрийн мэдлэг, чадварыг илэрхийлдэг онцлогтой. Хүүхдийн өдөр тутмын дасал үйл ажиллагаа, харилцааны явцад үнэлгээ хийх нь илүү үнэ цэнтэй мэдээлэл олж авахад тусалдаг.
- Нэмэлт үнэлгээ хийх, мэдээ баримтын багтаамж хэмжээг нэмэгдүүлснээр үнэлгээ заавал сайн болно гэсэн үг биш. Хүүхдийн асуудлаар ажиллаж байгаа мэргэжилтэн шаардлагатай мэдээллийг цуглуулж, цуглуулсан бүх мэдээллийг хэрхэн ашиглахыг урьдчилан мэдэж байх хэрэгтэй. Нийгмийн ажилтан шаардлагатай мэдээллийг цуглуулах боломж олгох үнэлгээний аргачлалыг оновчтой сонгох асуудал ихэд чухал.
- Зарим аргачлал нь бусдаасаа илүү үр өгөөжтэй байдаг. Зорилго, агуулга, баталгаат чанар, тохироц чанар, үр өгөөж, үнэ өртөг, хүртээмжтэй байдал зэрэг хүчин зүйл нь нүд татсан баглаа боодол эсвэл тод сурталчилгаанаас илүү чухал байдаг. Цуглуулсан мэдээлэл болон үнэлгээний үр дүнд гаргах дүгнэлт, шийдвэрийн чанар хамгийн чухал юм. Эцэстээ, бид ямар ч үнэлгээ хийсэн үр дүн нь хүүхэд, гэр бүл, хэрэгжүүлж буй хөтөлбөрт ач холбогдолтой, үнэ цэнтэй байх ёстой. Үнэлгээ нь мэдээлэл цуглуулж, нэгтгэх үйл явцаар хязгаарлагдахгүй, үр дүн нь шийдвэр гаргах, боломжийг нээн илрүүлэхэд чиглэнэ.
- Хүүхэд болон гэр бүлийн үнэлгээ нь хүүхдэд үйлчилгээ дэмжлэг шаардлагатай эсэх талаар шийдвэр гаргах зорилготой. Хүүхдэд үзүүлэх хариу үйлчилгээ нь заавал үнэлгээний ажлын дараа явагдах албагүй. Шаардлагатай тохиолдолд хүүхдэд үзүүлэх үйлчилгээ нь үнэлгээний үйл явцтай зэрэгцэн явагдаж болно.

Боловсрол, сэтгэцийн эрүүл мэнд, халамж, хүүхэд хамгаалал, гэр бүлд үзүүлэх үйлчилгээ болон нийгмийн үйлчилгээний бусад салбарт давуу талд суурилсан үнэлгээнд анхаарлаа хандуулах болсон. Давуу талд суурилсан үнэлгээ нь амжилтад хүрэх хүсэл тэмүүллийг

төрүүлдэг; гэр бүлийн гишүүд, үе тэнгийнхэн болон насанд хүрэгчидтэй найрсаг харилцаа тогтооход нөлөөлдөг; асуудал бэрхшээлийг даван туулах чадварыг нь нэмэгдүүлж байдаг; тал бүрийн хөгжилд нөлөөлдөг онцлогтой.

Давуу талд суурилсан үнэлгээ нь дараах зарчимд суурилдаг. Үүнд:

- Хүүхэд бүр давуу тал, нөөц боломжтой.
- Эцэг эх, багш нар болон бусад хүмүүсийн өөрт нь хандах хандлага хүүхдийг сэдэлжүүлдэг.
- Хүүхэд өөрийн чадвар, давуу талыг илэрхийлж чадахгүй байх нь түүний чадваргүй байдлыг илтгэхгүй.
- Хүүхдэд үзүүлэх дэмжлэг, үйлчилгээ нь түүний давуу талд суурилах ёстой.

Шаардлагатай мэдээллийг цуглуулахдаа дараах зүйлийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- хүүхдийн хөгжлийн хэрэгцээнд төвлөрөх,
- хүүхдийн хөгжлийн хэрэгцээг хангах эцэг эх/асран хамгаалагчийн нөөц боломжийг харгалзах,
- гэр бүлийн нөөц боломж, хүчтэй тал болон асуудал бэрхшээлийг тусгах,
- хүүхдийн сайн сайхан байдалд нөлөөлөх гэр бүлийн болон орчны хүчин зүйлийн нөлөөллийг авч үзэх.

Хүүхэд хамгааллын асуудалтай холбоотойгоор хүүхэд болон гэр бүлийг үнэлэхдээ:

- Хүүхэд болон гэр бүлийн хэрэгцээг тодорхойлно.
- Асуудал бэрхшээлийн онцлог, шаардлагатай дэмжлэг тусламжийг тодорхойлно.
- Хүүхэд, гэр бүлд тулгарсан бэрхшээлийг шийдвэрлэх арга замыг тодорхойлохын тулд уг асуудалд холбоотой хүчин зүйлсийг тэдний хувийн болон нийгэм, хүрээлэн буй орчныг хамруулан цогц байдлаар (эрсдэлийн үнэлгээ, давуу талын үнэлгээ, нөхцөл байдлын үнэлгээ) үнэлгээг хийнэ.
- Яаралтай шийдэх хэрэгтэй эрсдэл хүүхдэд тулгарч буй үед (жишээ нь хүүхэд хүчирхийлэгчтэй хамт амьдарч байгаа бол) цогц, дэлгэрэнгүй нөхцөл байдлын үнэлгээ хийх, үйлчилгээний/кейс төлөвлөгөө гаргахаас өмнө яаралтай интервенцийг хамгийн түрүүнд хийнэ.
- Нөхцөл байдлын үнэлгээ нь хүүхэд, түүний гэр бүл, найз нөхөд, цэцэрлэг, сургууль, ажлын газар, хөрш, хамаатан садан болон бусад эх сурвалжуудтай хийсэн мэдээлэл дээр үндэслэгдэнэ.
- Нөхцөл байдлын үнэлгээ хийхдээ үнэлгээний маягтыг хөтлөх, генограм, экозураглал, амьдралын түүхийн матриц, нийгмийн дэмжлэгийг үнэлэх зэрэг техникүүдийг ашиглаж, дүгнэлт гаргана.
- Нөхцөл байдлын үнэлгээний төгсгөлд хүүхдийн талаарх нэгдсэн дүгнэлт гаргаж, тулгамдаж буй асуудлуудыг тодорхойлно.

Хүүхдийг үнэлэх аргууд

Хүүхдийг үнэлэх аргууд формал бус (ажиглалт хийх, мэдээлэл цуглуулах, багшийн үнэлгээ, рейтингийг ашиглах г.м.) болон формал (асуулга, стандартчилагдсан тест зэрэг үнэлгээний арга хэрэгслүүдийг хэрэглэх) байж болно. Энэ хоёр аргын аль аль нь үр өгөөжтэй бөгөөд хүүхдийн хэрэгцээ, өсөлт хөгжлийн талаар мэдээлэл өгнө.

- Ажиглалт. Хүүхдийн үйл ажиллагаанд хамгийн бага хэмжээнд оролцож эсвэл оролцохгүйгээр ч ажиглалтыг явуулж болно. Хүүхдийн бие бялдар, оюун ухаан, хэл яриа, сэтгэлийн хөдөлгөөн, нийгэмшил зэргээр түүний хөгжлийн бүх талыг ажиглах боломжтой.
- Бүтээлийн сан буюу тодорхой хугацааны турш хүүхдийн хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны явц дах бүтээлд дүн шинжилгээ хийх арга юм. Бүтээлийн сан нь хүүхдийн хөгжлийн ахиц дэвшлийг тод томруун харуулдаг.
- Багш нарын үнэлгээ нь хүүхдийн танин мэдэхүй, хэл ярианы чадвар болон тэдний сэтгэлийн хөдөлгөөн, нийгэмшлийн чадварыг үнэлэхэд тохиромжтой байдаг. Энэ үнэлгээг стандартчилагдсан тестийн үнэлгээ болон үнэлгээний бусад аргуудтай хослуулж хэрэглэж болно. Багшийн үнэлгээг ашиглаж болно.
- Эцэг эхийн үнэлгээ нь үнэлгээний үйл явцад эцэг эхийг оролцуулах нэг боломж юм.
- Стандартчилагдсан тест гэдэг нь тест оношилгооны стандарт шаардлагын дагуу зохиогдсон тестүүд юм. Эдгээр тестийг стандарт аргаар хэрэглэж, үнэлдэг.
- Хүүхдийн үнэлгээнд проектив аргачлалуудыг хэрэглэх нь их байдаг. Учир нь ийм аргачлалуудын тусламжтайгаар зан үйлийн үл ухамсарлагдсан хэлбэрүүдийг судлах боломжтой байхын зэрэгцээ хүүхэд тоглох, зураг зурах, үлгэр түүх зохиох зэргээр өөрийн танил үйл ажиллагаанд оролцох боломжтой байдаг нь тэдний зан үйлийн онцлог илрэх боломжийг нэмэгдүүлдэг.








Генограммын арга техник

Энэ нь гэр бүлийг нэгэн систем болохын хувьд гэр бүлийн бүтцийг олон үеэр нь нэг хавтгайд зурагладаг техник юм. Энэхүү техник нь өөрийн гэсэн үндсэн тэмдэглэгээнүүдийг ашигладаг.

Анхаарах зүйлс:

- Зураглалыг зөв дүрслэх,
- Зүүн гар талаас эхэлж хүүхдүүдийн насны эрэмбээр байрлуулах,
- Тайлбар, тэмдэглэгээг заавал бичих


Тэмдэглэгээ

	Гей		Алга болсон эмэгтэй
	Лесби		Алга болсон эрэгтэй
	Бисексуаль		Хөгжлийн бэрхшээлтэй эрэгтэй
	Бисексуаль		Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэй
	Эрэгтэй-транс эмэгтэй		Хорт зуршлын хэрэглээтэй эрэгтэй
	Эмэгтэй-транс эрэгтэй		Хорт зуршлын хэрэглээтэй эмэгтэй
	Хоригдож байгаа эрэгтэй		Нас барсан эрэгтэй
	Хоригдож байгаа эмэгтэй		Нас барсан эмэгтэй


Зураг 2. Генограммын таних тэмдэг



Гэрлэлттэй холбоотой тэмдэглэгээнүүд



Жишээ:



Дүгнэлт: Үйлчлүүлэгч А нь 14 настай. Аав ээж нь 2010 онд салсан. Охин ээжтэйгээ, 2 ах нь аавтайгаа тусдаа амьдардаг. Охины ээж 2016 онд өөр хүнтэй гэрлэсэн. Одоогоор үйлчлүүлэгч А нь хойд аав, ээж, 2 дүүгийн хамт амьдардаг.


Экозураглалын арга техник

Энэ нь гэр бүл болон гэр бүлийн гишүүдийн бусад орчинтойгоо харилцах харилцааны дүр төрх, гэр бүл орчны харилцааны мөн чанар, нөөцийг дэлгэн нэгэн хавтгай дээр дүрслэн үзүүлдэг техник. Өөрөөр хэлбэл экозураглалын арга нь нөхцөл байдлын үнэлгээний дүнг богино хугацаанд илтгэх кейс тэмдэглэл мөн.


Анхаарах зүйлс:

- Зураглалыг зөв дүрслэх,
- Харилцааны хэв маягийг өнгө будгаар ялгаж дүрслэх,
- Тайлбар, тэмдэглэгээг заавал бичих.

Тэмдэглэгээ



Зураг 3. Экозураглалын тэмдэглэл



Генограмм, эко зураглал зурахдаа анхаарах зүйлс:

- Үйлчлүүлэгчийн хувийн мэдээллийг бүтнээр бичихгүй байх
- Таних тэмдэглэгээг өнгө будгаар ялгах, тайлбар бичих
- Генограмм, эко зураглал тус бүр дээр дүгнэлт хийх

Гурав. Үйлчилгээг төлөвлөх

Нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээг хийж үйлчлүүлэгчийн мэдээллийг цуглуулсан дүгнэлтэд үндэслэн үйлчилгээний төлөвлөгөө боловсруулна. Төлөвлөгөө нь нийгмийн ажлын үйлчилгээний эцсийн зорилгыг биелүүлэх буюу түүнд хүрэх зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааг чиглүүлдэг баримт бичиг юм. Төлөвлөгөө нь тогтоосон холбоо харилцаа, олж авсан мэдээлэл нь нийгмийн ажилтны үйл ажиллагааны үр дүнд бий болдог бөгөөд цаашдын үйлчилгээг хүргэхэд үндэс суурь нь болдог.

- Үйлчилгээний төлөвлөгөө нь тодорхой, бодитой байх ёстой бөгөөд хүүхэд, гэр бүлийн давуу тал дээр суурилсан, нөхцөл байдлын үнэлгээний дүгнэлтэд тулгуурлаж боловсруулагдана.
- Үйлчилгээний төлөвлөгөөнд хүүхэд, түүний гэр бүлд учирч болзошгүй аюулгүй байдлын эрсдэлийг бууруулахын тулд үзүүлэх үйлчилгээг нарийн тусгана.
- Зарим тусгай нөхцөл байдалд нэг гэр бүлийн гишүүн бүрт зориулсан төлөвлөгөө гаргаснаас хүүхэд бүрийн онцлог хэрэгцээг тусгасан гэр бүлийн төлөвлөгөө гаргана.
- Нийгмийн ажилтан тухайн хүүхдэд тулгарсан асуудлыг хувь хүн, гэр бүл, бүлэг, байгууллага, олоннийтийн түвшинд шийдвэрлэх, эрхийг нийгмийн саад бэрхшээлгүй эдлэхэд нь дэмжлэг үзүүлнэ.
- Үйлчилгээний төлөвлөгөө нь бодитой, хэрэгжихүйц байх бөгөөд нийгмийн ажилтан нь хүүхдэд одоогийн байгаа нөөц боломжийн хүрээнд хийх үйлчилгээнүүдийн талаар дэлгэрэнгүй тусгаж, үйлчилгээний гэрээ байгуулна.
- Мэргэжлийн, цогц, чанартай үйлчилгээ үзүүлдэг байгууллагад тухайн кейсийг холбон зуучлах эсвэл шилжүүлнэ.
- Нарийн төвөгтэй кейсийн хувьд төлөвлөгөө боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх, үнэлэхийн тулд хамтарсан багаар ажиллах, мэргэжлийн байгууллагууд хоорондын хамтарсан хурлаар кейс хэлэлцүүлэг хийж, тэмдэглэл хөтөлнө.

Дөрөв. Үйлчилгээг хүргэх, хэрэгжүүлэх

Хамтран боловсруулсан үйлчилгээний төлөвлөгөөний дагуу үйлчлүүлэгчтэй ажиллах, үйлчилгээ үзүүлэх арга зам, интервенцийг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ.

- Үйлчилгээний төлөвлөгөөний үндсэн дээр нийгмийн ажлын үйлчилгээ хэрэгжүүлнэ.
- Үйлчилгээний төлөвлөгөөнд дэлгэрэнгүй дурдагдсан үйлчилгээг хүргэхдээ хүүхэд, түүний гэр бүл, нийгмийн орчинтой ажиллана.
- Хүүхэд, гэр бүлийн нийгэм сэтгэл зүйн дэмжлэг, гэрээр тогтмол очих, гэр бүлийн гишүүдтэй уулзах зэрэг үйлчилгээг үзүүлнэ.
- Хүүхдийг мэргэжлийн үйлчилгээ, орон нутгийн дэмжлэгийн эх үүсвэртэй холбон зуучлах үйлчилгээнд хамруулна.
- Холбон зуучлах үйлчилгээ бүрд холбон зуучлах маягт бөглөж энэ талаар кейсийн файлд заавал тэмдэглэж, холбон зуучлалын одоогийн нөхцөлийг тэмдэглэнэ.
- Хүүхэд, түүний гэр бүлийг холбон зуучилж болох байгууллагуудын жагсаалтыг гаргаж, холбон зуучлах үйлчилгээний зураглалыг байнга шинэчилнэ.
- Холбон зуучлах үйлчилгээнд боловсрол, ус ариун цэвэр, хүүхэд хамгаалал, хүнс тэжээл, эрүүл мэнд, хууль эрх зүй, эдийн засгийн чадавхжуулалд зэрэг төрлүүд хамаарна.

- Зайлшгүй шаардлагатай гэдэг зарчмаар мэдээлэл хуваалцах, хамааралгүй мэдээллийг хуваалцахгүй байхыг анхаарч ажиллана.
- Хүүхэд, түүний гэр бүлд үзүүлж байгаа үйлчилгээ нь үнэ төлбөргүй байх ёстой ч зарим нөхцөл байдалд төлбөртэй үйлчилгээ авахад дэмжлэг үзүүлнэ.

Холбон зуучлах

Хүүхдэд хамгааллын үйлчилгээг хүргэхэд заримдаа өөр мэргэжилтний зөвлөгөө, дэмжлэгийг авах шаардлага гардаг. Тухайлбал, зан үйлийн өөрчлөлттэй хүүхэдтэй ажиллахад мэргэшсэн сэтгэл зүйч, сэтгэл засалчийн зөвлөгөө гэх мэт тусламж хэрэгтэй болдог.

Хохирогч, түүний гэр бүлийн гишүүдэд хүчирхийллийн улмаас учирсан, учирч болзошгүй хор уршиг, үр дагаврыг арилгах зорилгоор шаардлагатай хамгаалалт, үйлчилгээ, тусалцаа (цаашид “үйлчилгээ” гэнэ) үзүүлэх, холбогдох мэргэжилтэн, байгууллагатай холбож өгөх, үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавих, үнэлэх цогц үйл явцыг холбон зуучлах үйлчилгээ гэж хэлнэ. Өөрөөр хэлбэл нөхцөл байдлын үнэлгээгээр хүүхдэд тусламж, үйлчилгээ үзүүлэх дүгнэлт гарсан бол иргэний бүртгэл, сэтгэл зүй, хууль зүй, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн болон бусад шаардагдах үйлчилгээнд холбон зуучлах явдал юм.

Хүснэгт 4. Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх үе шат, анхаарах зүйлс

Үе шат	Анхаарах зүйлс
1. Үйлчлүүлэгчийн нөхцөл байдал, хэрэгцээг тодорхойлох	<ul style="list-style-type: none"> • Тухайн хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдал, эрсдэлийг үнэлэх • Хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, боловсрол, нийгэм-сэтгэл зүйн байдлыг үнэлэх • Хүүхдийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлагыг тодорхойлох
2. Үйлчлүүлэгчид хэрэгцээтэй үйлчилгээ, нөөц боломжийг судлах	<ul style="list-style-type: none"> • Хүүхдийн дээд эрх ашигт нийцүүлэн аюулгүй, найдвартай үйлчилгээгээр хангах зураглалаа шинэчлэх • Үйлчилгээ үзүүлэх боломжтой байгууллагуудын жагсаалтыг гаргах, шинэчлэх, үнэлэх
3. Үйлчлүүлэгчийг хамгаалалт, үйлчилгээ, тусалцаа, дэмжлэгтэй холбох	<ul style="list-style-type: none"> • Хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлэх, холбон зуучлахдаа тэдний зөвшөөрлийг авах • Хүүхэд, гэр бүлд холбон зуучлах үйлчилгээний талаар тайлбарлах, давуу болон эрсдэлийн талаар тайлбарлах • Холбон зуучлах үйлчилгээний илгээх хуудас бүхий Маягтыг илгээх, кейс файлд хавсаргах
4. Үйлчилгээний чанарт хяналт тавих, эргэх холбоотой байх, үнэлэх	<ul style="list-style-type: none"> • Холбон зуучлах үйлчилгээний Маягт 2, 3 -ыг ашиглах, бүрдүүлэх, кейс файлд хавсаргах • Хүүхэд, гэр бүл болон үйлчилгээ үзүүлсэн байгууллагатай эргэх холбоотой байх, үйлчилгээний үр дүнг үнэлэх • Өөр нэмэлт үйлчилгээ хэрэгтэй эсэхэд анхаарах

Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэхдээ сургуулийн нийгмийн ажилтан дараах зүйлийг эрэлхийлэх хэрэгтэй. Үүнд:

- Хүүхэд, тэдний гэр бүлийн хүсэлтийн дагуу үйлчилгээ хүргэх боломжтой байгууллагыг олж хайх,
- Тухайн байгууллагын талаар мэдээллийг өгөх,
- Үйлчилгээ үзүүлэх байгууллагын нийгмийн ажилтныг тодорхой зааж өгөх, уулзах өдөр, цагийг товлох, урьдчилан холбогдох, мэдээлэх,

- Нийгмийн ажилтан хүүхдийн цаашдын үйлчилгээний үр дүнг дүгнэх, эргэн холбоотой байх,
- Холбон зуучилсан байгууллагатайгаа байнга холбоотой байх /Холбон зуучлах үйлчилгээний 3 маягтыг ашиглана/,
- Хүүхэд, тэдний гэр бүлийг дэмжих, гэр бүлийн гишүүдийг боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, хууль эрх зүйн тусламж, дэмжлэгт холбон зуучлах үйлчилгээг үзүүлнэ.

Хүснэгт 5. Хамтарсан багаар үзүүлэх холбон зуучлах үйлчилгээ

Хамтарсан багийн үйлчилгээ	Холбон зуучлах үйлчилгээ
Аюулгүй байдлын хамгаалалт: Түр хамгаалалтаар хангах	Хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалт
Сэтгэлзүйн үйлчилгээ: Сэтгэл зүйн зөвлөгөө	Сэтгэл заслын үйлчилгээ
Эрхзүйн туслалцаа: Эрх зүйн зөвлөгөө	Өмгөөллийн үйлчилгээ
Хүүхэд хамгааллын үйлчилгээ: Аюулгүй байдлыг хангах, түр хамгаалалтаар хангах, гэр бүлд нь эргэн нэгтгэх	Хүүхдийг суурь боловсролын тасралтгүй үйлчилгээнд хамруулах, Хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ
Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ: Өрхийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ	Эмнэлгийн мэргэшсэн сувилахуйн болон сэргээн засах тусламж үйлчилгээ
Нийгмийн халамжийн үйлчилгээ: Нийгмийн халамжийн үйлчилгээ, нийгмийн хөгжлийн үйлчилгээ	Асрамж халамжийн хувилбарт болон төрөлжсөн үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, мэргэжлийн сургалт, бүртгэлд хамруулах, бусад
Бусад дэмжлэг, туслалцаа: Хүүхэд хохирогчийг төлөөлөх, уулзалтын зөвшөөрөл олгох	Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд шилжүүлэх

Холбон зуучлах үйлчилгээг сайжруулахын тулд орон нутгийн хүүхдийн байгууллага, хамтарсан баг нь тухайн үйлчилгээнд оролцогч тал тус бүрийн үүрэг хариуцлагыг тодорхой болгох хэрэгтэй.

Холбон зуучлах үйлчилгээ нь дараах шаардлагыг хангасан байна:

- Хамгаалах үйлчилгээ шаардлагатай хүүхдийн шалгуур үзүүлэлт (эрсдэлийн түвшин)-ийг тодорхой болгох;
- Орон нутгийн хүүхэд хамгааллын байгууллага болон бусад байгууллагын үүрэг хариуцлагыг тодорхойлох;
- Холбон зуучлах үйлчилгээ үзүүлэх боломжтой байгууллагуудыг тодорхойлох;
- Холбон зуучлах үйлчилгээ хэрхэн хэрэгжихийг тодорхой болгох (шаардлагатай мэдээлэл авах, үйлчилгээний санал асуулга авах гэх мэт);
- Байгууллагаас үйлчилгээ авахын тулд хүүхэд, гэр бүл, асран хамгаалагчдад ямар мэдээлэл шаардлагатайг тодорхой болгох;
- Шаардлагатай мэдээллийг хэрхэн хүргэхийг тодорхой болгох (мэдээ тайлан, утас, биечлэн уулзах);
- Нөхцөл байдлын үнэлгээ хийсний дараа шалгуур үзүүлэлтийг биелүүлээгүй бол хэрэгжүүлэх алхмыг тодорхой болгох шаардлагатай.

Хүснэгт 6. Холбон зуучлах үйлчилгээнд анхаарах асуудал

Ямар тусламж шаардлагатай байгаа	Хүүхэд аюултай нөхцөл байдлад байгаа эсэх	Гэр бүл/ Өрхийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл	Гэр бүлд үйлчилгээ үзүүлж буй байгууллага, мэргэжилтнүүд	Өөр асуудал байгаа эсэх	Анхаарах зүйлс
<p>Материаллаг нөөц: Байрлах газар, ор, хувцас, мөнгө болон бусад Эцэх эх/асран хамгаалагчдад үзүүлэх бодит тусламж: Түр асрамж болон бусад Эцэх эх/асран хамгаалагчдад үзүүлэх дэмжлэг Ярилцах, мэдээлэл/ зөвлөгөө өгөх мэргэжилтэн Холбон зуучлах үйлчилгээ хүргэгчид үзүүлэх дэмжлэг:</p>	<p>Мэдээллийн эх сурвалж: Холбон зуучлах үйлчилгээ хүргэгчийн ажигласан асуудал Хүүхэд холбон зуучлах үйлчилгээ хүргэгчид хэлэх Хэн нэгэн холбон зуучлах үйлчилгээ хүргэгч болон бусад (хэн болохыг тэмдэглэх)-д хэлэх Холбон зуучлах үйлчилгээ хүргэгч санаа зовж байгаа Яагаад одоо тусламж хүсэж байгаа вэ? Холбон зуучлах үйлчилгээ хүргэгч яагаад санаа зовж байна вэ? Шууд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна уу? дэлгэрэнгүй тайлбар Хүчирхийлэл үйлдэгчийн одоогийн байршил Эмнэлгийн болон шүүх эмнэлгийн нотлох баримтууд</p>	<p>Хүүхэд: Нэр, нас, хүйс, угсаа гарал, хаяг болон утасны дугаар Холбон зуучлах үйлчилгээ хүргэгч: Нэр, хаяг, утасны дугаар Холбон зуучлах үйлчилгээ хүргэгч болон хүүхдийн хоорондын харилцаа холбоо: Эцэг эх/асран хамгаалагч Нэр, хаяг, утасны дугаар, 18-аас доош насны бол насыг тэмдэглэх Эцэг эх/асран хамгаалагчтай уулзах Ийм төрлийн уулзалт шаардлагатай байна уу? Гэр бүл дэх бусад хүүхдүүдийн нас болон хүйс Эцэг эх/асран хамгаалагч Гэр бүлийн угсаа гарал Гэр бүлийн шашин шүтлэг Хүүхэд болон эцэг эх хөгжлийн бэрхшээлтэй байдал</p>	<p>Сургууль/ цэцэрлэг: Хаяг, утасны дугаар болон нийгмийн ажилтан, анги удирдсан багшийн нэр Эрүүл мэндийн ажилтан: Нэр, хаяг болон утасны дугаар Ерөнхий эмч: Нэр, хаяг болон утасны дугаар Батлан даах үйлчилгээ: Нэр, хаяг болон утасны дугаар Хэрэв байгаа бол бусад мэргэжилтнүүдийг оруулах Хувилбарт үйлчилгээ үзүүлэгч: Нэр, хаяг болон утасны дугаар</p>	<p>Энэ бол шалгах хуудас биш гэдгийг санаарай. Үүнд: Хүүхэд/эцэг эхийн зөрчил маргаан Эм бодис/ архины зохисгүй хэрэглээ Орон байрны асуудал/Гэр оронгүй байдал Тусгай хэрэгцээт хүүхдийн боловсрол Сургууль завсардалт Хөгжлийн бэрхшээл Ялгаварлан гадуурхалт Дарамт хүчирхийлэл Дээрлэлт Хүүхдийн зан төлөв Гэр бүл/ гэрлэлтийн талаарх зөрчил Санхүүгийн хямрал Сэтгэцийн эмгэг Өвчин эмгэг Ядуурал Ажилгүйдэл</p>	<p>Энэ байгууллага үйлчилгээ үзүүлж чадах уу? Хэрэв үгүй бол холбон зуучлах үйлчилгээ хүргэгчид хаана холбогдох талаар мэдээлэл өгөөрэй. Хангалттай мэдээлэл авсан уу? Хэрэв үгүй бол хаанаас авч болох вэ? Боломжит үйлчилгээ байна уу? Холбон зуучлах үйлчилгээ хүргэгч шууд очихыг хүсэж байна уу? Хэлмэрч/дохियोны хэлээр ярьдаг хүний дэмжлэг шаардлагатай байна уу? Хүрэх газарт анхаарах шаардлагатай зүйл байна уу?</p>

<p>Зөвлөгөө/мэдээлэл, анхаарал хандуулж буй зүйлсийн талаар ярилцах болон бусад Хүүхдэд үзүүлэх бодит тусламж</p> <p>Байрлах газар, сургууль, тусгай хэрэгцээт хүүхдэд зориулсан хэрэгсэл</p> <p>Хүүхдэд үзүүлэх дэмжлэг:</p> <p>Найз нөхөд болох, зөвлөгөө өгөх, өсвөр үеийнхэнд зориулсан хөтөлбөр болон бусад Хүүхдэд үзүүлэх хамгааллын үйлчилгээ:</p> <p>Гэрээр нь эргэх, хамгаалах байранд авах болон бусад</p>	<p>Биед нь шарх, гэмтэл үүссэн бол түүний хэмжээ, өнгө, хэлбэр болон байршил нь хаана байна вэ?</p> <p>Хүүхэд үл хайхрагдсан бол түүний гадаад байдал, хувцаслалт болон гэр бүлийн орчин, нөхцөл ямар байна вэ?</p> <p>Хүүхдийн нөхцөл байдал ямар байна вэ?</p> <p>Хэрэв хүүхэд бэлгийн хүчирхийллийн хохирогч бол хүүхдийн талаарх мэдээлэл болон хүүхдийн зан төлөв ямар байна вэ?</p> <p>Хэрэв хүүхэд сэтгэл санааны эсрэг хүчирхийлэлд өртсөн бол хүүхдэд ямар зан төлөв ажиглагдаж байна вэ?</p> <p>Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж буй хүн байна уу?</p> <p>Ямар нэгэн тайлбар байна уу?</p> <p>Дэлгэрэнгүй мэдээлэл:</p> <p>Хүүхэд одоо хаана байрлаж байна вэ?</p> <p>Хамгийн сүүлд хүүхэдтэй уулзсан огноо</p> <p>Өмнө анхаарал хандуулж байсан асуудлууд</p> <p>Одоо анхаарал хандуулж буй асуудлууд</p> <p>Анхаарал хандуулж буй асуудлын шалтгаан, болж буй тодорхой үйл явц, шарх гэмтэл</p> <p>Асуудал хэзээ тулгарсан бэ?</p> <p>Хүүхдийн эцэг эх/асран хамгаалагчийн талаарх мэдээлэл</p> <p>Хүчирхийллийн нотлох баримтууд.</p>		<p>Нотолгоо, шаардлагатай байна уу? (Холбон зуучлах үйлчилгээ хүргэгчийн нотлох баримтыг хамгаалах хэрэгтэй үед гэх мэт.</p> <p>Авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар холбон зуучлах үйлчилгээ хүргэгчээс санал хүсэлт авах</p> <p>Уулзалтыг хэрхэн төгсгөх вэ? Хэлэх, асуух өөр шаардлагатай зүйлс байна уу?</p> <p>Авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хэн нэгнээс зөвлөгөө авах шаардлагатай байна уу?</p> <p>Нягтлах:</p> <p>Хүүхэд/эцэг эх холбон зуучлах үйлчилгээ хүргэгчийн талаар ойлголттой байгаа юу?</p> <p>Гэр бүл/хүүхэд тухайн байгууллагын талаар мэдэж байгаа юу?</p> <p>Гэр бүл/хүүхэд одоо үйлчилгээ авч байна уу?</p> <p>Хэрэв хүүхдийг дарамт хүчирхийлэлд өртсөн гэж таамаглаж байгаа бол Хүүхэд хамгааллын байгууллагад хандаарай:</p> <p>Холбоо барих шаардлагатай утасны дугааруудын жагсаалт</p>
---	---	--	--

Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хэн хамгаалах вэ?

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч хүүхэд болон түүний эдлэх эрх, хамгаалалтын арга хэмжээг авахдаа хүүхдийн эрх, ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавих үүрэгтэй. Хүүхдийн эрхийг хамгаалж байна гээд эцэг эхээс нь салгах үүрэг байхгүй хэдий ч холбогдох чиглэлийн албан хаагчид үнэлэлт дүгнэлт өгөх үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэнэ.

- Хүүхэд гэдэг нь 18 насанд хүрээгүй хүний хэлнэ.
- Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах нь төрийн үүрэг.
- Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, гэр бүлийн бусад гишүүн хамгаалах үүрэгтэй.
- Насанд хүрсэн хүн нь хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архидан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.

Хүснэгт 7. Хохирсон хүүхдийн эрх ба түүнийг хамгаалах

Хохирогч хүүхдийн эрх	Хэн хийх вэ
Нөхөн төлбөр авах эрх Хувийн мэдээлэл нууцлалтай байх Хүчирхийлэл үйлдэгчтэй холбоо тогтоохгүй байх Аюулгүй байдлын хамгаалалт авах эрх Сэтгэлзүйн хамгаалалт авах эрх	Хууль ёсны төлөөлөгч Монголын хуульчдын холбооноос хүүхдийн эрхээр ажилладаг мэргэшсэн өмгөөлөгч томилох Хүүхдийн асуудлаар мэргэшсэн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч байх Хүүхдийн эрхийн улсын байцаагч
Хууль ёсны төлөөлөгчийн хамт Шүүх хуралдаанд оролцох эрх	Хууль ёсны төлөөлөгчөөрөө дамжуулан хэрэг хянан шалгаж буй мөрдөгч, прокурор, шүүгчид хүсэлт гаргах хэлбэрээр оролцох
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохгүй байх эрх хэрэг бүртгэл, мөрдөн шалгах үе Прокурорын үе Шүүх хуралдааны үе	Хууль ёсны төлөөлөгч болон өмгөөлөгчөөрөө дамжуулна. Хүүхдийг тусгайлсан хүүхдийн өрөөнд хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл авах түүнийгээ дүрсжүүлэх Сэтгэл зүйчтэй оролцох Мэргэшсэн өмгөөлөгч, хүүхдийн байгууллагын ажилтан, нийгмийн ажилтан байх

Хүснэгт 8. Хүүхдийн эрх зөрчигдсэн тохиолдолд хамгаалах хуулийн зохицуулалт

Хүүхдийн эрх зөрчигдсэн тохиолдолд	Зохицуулагдах хууль
Хэрэв хүүхэд гэр бүлийн хүчирхийллийн хохирогч, эцэг эхийн ашиг сонирхол нь хүүхдийн эрх ашигт харшлах юм бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагын ажилтныг (тусгай асран хамгаалагч) томилохоор шүүх, прокурорт хандана. Тусгай асран хамгаалагч нь хохирогч хүүхэдтэй холбоотой бүхий л мэдэгдлийг гаргаж, хохирогчийн эрх эдэлнэ	Гэмт хэргийн хохирогч хүүхдийн эрх ашиг сонирхлыг ЭХ-ийн 16 бүлэг Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, ЭХХШТХ-ийн 8.2-рт Хохирогчийн эрх Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 Хүүхдийн эрхийг зөрчих хуулиар зохицуулагдана. Бусад хуулиуд болох Гэр бүлийн тухай хууль, хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Иргэний хууль, Иргэний хэргийг хянан шийдвэрлэх тухай хуулиар хамгаалалтыг хангах юм
Хүүхдийн эрхийг зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага оногдуулах вэ? Эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах Торгох Олон нийтэд тустай ажил хийлгэх Зорчих эрхийг хязгаарлах Тодорхой хугацаагаар хорих Сургуулийн нийгмийн ажилтан, багш, сургуулийн захиргааг торгоно	

Тав. Үйлчилгээг үнэлэх

Нийгмийн ажилтны үзүүлсэн үйлчилгээ чанартай байх гэсэн хариуцлагыг хүлээх ёс зүйг нийгмийн ажилтнууд хүлээх ёстой. Үйлчилгээнд явцын болон эцсийн үнэлгээ хийдэг.

- Нийгмийн ажилтан хүүхдэд хүргэсэн үйлчилгээг явцын, эцсийн үнэлгээгээр үнэлсэн байна.
- Нийгмийн ажилтан үйлчилгээний төлөвлөгөөнд тусгасан зорилго, зорилтууд биелэгдсэн байдал, өөрчлөлт хийх шаардлагатай эсэхийг үнэлнэ.
- Үйлчилгээг үнэлэхэд хүүхэд, түүний гэр бүлийг оролцуулна.
- Нийгмийн ажилтан нь үзүүлж буй үйлчилгээнийхээ талаар хүүхдийн санал бодол, үнэлгээг авч цаашдын үйлчилгээ, үйл ажиллагаандаа тусгана.
- Нийгмийн ажилтан нь хүүхдээс сэтгэл ханамжийн судалгаа авах, ахлах нийгмийн ажилтан-мэргэжлийн удирдагч болон хамтран ажилладаг мэргэжилтнүүдийн санал бодлыг сонсох замаар өөрийн үйлчилгээний үйл явц, үр дүн, үр нөлөөг үнэлнэ.
- Нийгмийн ажилтан нь үйлчилгээнийхээ үйл явц, үр дүн, үр нөлөөнд хийсэн үнэлгээг өөрийн болон байгууллагын үйлчилгээг сайжруулахад ашиглана.

Зургаа. Үйлчилгээг хаах


Нийгмийн ажилтан үйлчилгээгээ амжилттай дуусгах, үйлчлүүлэгчийн бие даасан байдлыг хангах, өөрийн амьдралыг цаашид өөрөө зохицуулан авч явах зан үйлийн болон бусад чадварыг дэмжихэд чиглэгддэг.

- Хүүхдэд үзүүлсэн үйлчилгээний зорилгодоо хүрсэн, хүүхэд хөнөөлгүй аюулгүй орчинд амьдрах болсон, хүүхдийн сайн сайхан хангагдсан үед кейс хаагдана.
- Хүүхэд, гэр бүл өөр орон нутагт албан ёсоор шилжиж өөр байгууллага, хөтөлбөрт хамрагдах болсон үед кейс хаагдана.
- Хүүхэд нас барсан бол кейс хаагдана. Хэрвээ хүүхэд нас барсан бол гэр бүлд, бусад хүүхэд эрсдэлд байгаа юу гэдгийг анхаарч ажиллана.

- Хүүхэд 18 нас хүрмэгц кейсийг хаана. Хүүхдүүд насанд хүрээд тохирох үйлчилгээ авах талаар кейс төлөвлөгөөнд оруулах ёстой. Энэ нь төвлөрсөн асрамжаас гарч байгаа хүүхдүүдэд зориулсан хувилбарт үйлчилгээнд ашиглана.
- Үйлчилгээг хаасны дараа хүүхдийн аюулгүй байдлыг анхаарч ажиллана.
- Хүүхдийн нөхцөл байдал өөрчлөгдсөн үед (тухайлбал хамгааллын асуудал гарч дэмжлэг хэрэгтэй болсон үед) хааж, дахин нээж болно.
- Нийгмийн ажилтан үйлчилгээг хаах тэмдэглэл бичиж хүүхдэд танилцуулна.
- Өмнөх уулзалт бүрийн төгсгөлд хамтдаа хийсэн ажлаа нэгтгэн дүгнэж, уулзалтын тэмдэглэл хөтөлж танилцуулна.
- Үйлчилгээг хаах хугацааг үйлчилгээ эхэлсэн үеэс эхэлж хүүхдэд танилцуулж ойлгуулна.
- Үйлчилгээг хаахдаа эрсдэлийн хүчин зүйлс, түүнийг бууруулах чиглэлээр хийсэн ололт амжилтыг эргэн дүгнэх, үзүүлсэн үйлчилгээ, асуудлыг шийдэхийн тулд хийсэн үйл ажиллагаа, цаашид анхаарах, санаа зовж буй асуудлын тухай дүгнэнэ.

Кейс файлд (хувийн хэрэг) байх шаардлагатай материал:

Кейс файл гэдэг нь үйлчлүүлэгчийн хувийн хэрэг, тухайн үйлчлүүлэгчийн хувийн мэдээлэл, түүний гэр бүлийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, үйлчилгээ авсан, үйлчилгээ хаасан, үйлчилгээг зогсоосон, шилжүүлсэн, холбон зуучилсан, холбогдох нууцлалтай материалууд бүхий нотлох баримт юм.



Энэхүү стандартаас дэлгэрүүлж судлаарай

Кейс файлд заавал байх дараах материалуудыг эргэж нягтлаарай.

- Хүүхдийн талаарх үндсэн мэдээлэл: Хүүхэд болон түүний гэр бүлийн тухай мэдээлэл (Нэр, нас, төрсөн огноо, эцэг эх, одоогийн байдлаар хамт амьдарч буй гэр бүлийн бусад гишүүдийн болон холбоо барих мэдээлэл)
- Хүүхдийн санаа зовж буй асуудал, тулгамдаж буй асуудлаа тодорхойлсон байдал
- Хүүхдийн одоогийн амьдарч буй гэр бүлийн бүтэц, нөхцөл байдал
- Эрүүл мэндийн байдал
- Боловсролын байдал
- Хөдөлмөр эрхлэлтийн байдал
- Санхүүгийн байдал
- Сэтгэл зүйн байдал
- Орон сууцны байдал
- Эрсдэлийн үнэлгээ дүгнэлт
- Шийдвэрлэх шаардлагатай тулгамдаж буй асуудал
- Нийгмийн ажлын үйлчилгээ өмнө нь авч байсан бол нийгмийн ажилтантай холбоо барих мэдээлэл (Үйлчилгээ үзүүлсэн байгууллага, авсан үйлчилгээ, үйлчилгээний үр дүнгийн тухай бүртгэл, кейс файлын хамт)
- Үйл явцын тэмдэглэл, уулзалтын тэмдэглэл
- Үзүүлсэн интервенц
- Хүүхдэд гарч буй өөрчлөлтийн тэмдэглэл, ажиглалтын хуудас
- Үйлчилгээний үр дүнг үнэлэх хуудас
- Үйлчилгээг хаах тэмдэглэлийн маягт
- Үйлчилгээ дууссаны дараах тодорхой хугацаанд хүүхдийн нөхцөл байдлыг үнэлсэн тэмдэглэл, ажиглалтын хуудас
- Хүүхэдтэй холбоотой баримт бичгүүд
- Хамтарсан багийн уулзалтын тэмдэглэл, үнэлгээ, тусламж үйлчилгээ үзүүлсэн талаарх мэдээлэл
- Үйлчилгээний төлөвлөгөөг баталгаажуулсан байх, үзүүлсэн үйлчилгээний хураангуй
- Ахлах нийгмийн ажилтан болон мэргэжлийн удирдагчийн явцын үнэлгээ хийсэн талаар нотолгоо, баримт
- Кейс файлтай танилцсан ахлах нийгмийн ажилтан, мэргэжлийн удирдагчийн албан ёсоор хүлээн зөвшөөрсөн огноо, гарын үсэг
- Мэргэжлийн удирдагчийн албан ёсны үнэлгээ, хяналт шинжилгээний дүгнэлт
- Удирдамж чиглэлийн дагуу хамтран ажилласан байгууллагын хооронд аман, бичгээр дамжуулсан мэдээлэл, цаг хугацаа
- Аудио, видео бичлэгүүд, гэрэл зураг болон бусад нотлох баримтууд

Хүүхдийн кейс файл (хувийн хэрэг) өөр бусад нийгмийн ажилтан болон байгууллагаас шилжиж ирсэн, холбон зуучилсан үйлчилгээнд хавсаргах шаардлагатай мэдээлэл

- Кейс файл шилжүүлсэн огноо, байгууллага, холбоо барих мэдээллийг бичнэ.
- Кейс файл шилжүүлсэн мэргэжилтний нэр, албан тушаалыг заавал бичнэ.
- Кейс файлыг шилжүүлсэн зорилго, үйл явцын тухай товч тэмдэглэлийг заавал бичнэ.
- Шаардлагатай тохиолдолд өмнө үйлчилгээ үзүүлж байсан мэргэжилтэнтэй холбоо барих мэдээллийг заавал оруулна.
- Кейс файл шилжүүлэхийн тулд харилцан тохиролцсон үр дүн, алхмуудыг тэмдэглэнэ.

- Кейс файлд холбон зуучлах үйлчилгээ үзүүлсэн бол илгээх хуудас, хамтарсан төлөвлөгөө, эргэн мэдээлэх хуудас бүхий маягтуудыг хөтөлж, заавал оруулна.
- Цаашид кейс файлыг (хувийн хэрэг) хөтлөх мэргэжилтний гарын үсэг, хүлээн авсан огноог заавал тэмдэглэнэ.

Хүүхдийн кейс файл (хувийн хэрэг) хөтлөх, хадгалахад тавигдах шаардлага

- Хүүхдийн нэрийг нууцлах зорилгоор код бичиж (нийгмийн ажилтны мэдээллийн сан), кейс файл тус бүрийг кодлох бөгөөд хэвлэсэн тохиолдолд кейс файлын хавтасны нүүрэнд кодыг нь бичнэ (Кейс файлын нүүрэн хэсэгт хүүхдийн нэрийг огт бичихгүй).
- Кейс файлын товъёг хийж, хуудас дугаарлаж, нийт хуудасны тоог бичнэ.
- Кейс файлын код, уг кодоод хамаарах хүүхдийн нэр бүхий жагсаалтыг файл байгаа газраас өөр газарт хадгална. Баримтыг хадгалах, тухайн кейстэй холбоотой цахим шуудан илгээнэ.
- Гар утас, таблетыг нууц үг үүсгэн хамгаалж, зөвхөн нийгмийн ажилтан тэдгээртэй харилцана. Таблетад кейсийн талаар аль болох бага мэдээллийг хадгалбал зохино. Тодруулбал, таблетад оруулсан мэдээллийг үндсэн мэдээллийн баазад аль болох хурдан хуулж авсны дараа, таблетад буй мэдээллийг устгана.
- Нийгмийн ажилтан хүүхдийн гэрт очих юм уу эсхүл тодорхой хугацаанд л кейсийн талаарх мэдээллийг таблетад хадгалах, таблетын дэлгэц нь автоматаар түгжигддэг байхаас гадна гээгдсэн эсхүл хулгайлагдсан тохиолдолд кейсийн мэдээлэл автоматаар устгагддаг тохируулгатай байна.
- Кейс файлыг нийгмийн ажлын мэргэжлийн түвшинд хөтлөх шаардлагатай. Зайлшгүй ашиглах маягтууд:
 - Хүлээн авах хуудас
 - Нөхцөл байдлын үнэлгээний маягт
 - Үйл явцын тэмдэглэл
 - Үйлчилгээний төлөвлөгөө, үйлчилгээний гэрээ
 - Үнэлгээний хуудас
 - Шилжүүлэх хуудас
 - Холбон зуучлах маягтууд
 - Уулзалтын бичлэгийг дуу хураагуурт бичих, үйл явцын тэмдэглэлийг заавал хөтөлнө.
- 3 сар тутамд кейс файлын (хувийн хэрэг) бүртгэлд хийсэн ажлын тайланд үйлчилгээний төлөвлөгөөний зөвлөмж, үр дүнгийн явцыг тусгана.
- Цахим мэдээллийн баазыг нууц үг үүсгэн хамгаалах бөгөөд үзэж болох мэдээллийн хүрээг ажилтны албан үүргээс хамааран ялгаатайгаар тогтооно. Хүүхдийн тухай бүхий л мэдээлэлтэй харилцах хүн нь нийгмийн ажилтан байх бол мэргэжлийн удирдагч болон мэдээллийн удирдлагын багийнхан кодолсны дараа уг мэдээллийг үзнэ.
- Цаасаар эсхүл цахим мэдээллийн бааз бүхий гар утас, таблет, компьютер зэргийг найдвартай газар байлгаж, тэдгээрт нэвтрэхэд хязгаар тавьж, нэвтрэх код хийнэ.
- Цаасан файлуудыг зориулалтын цоожтой шүүгээнд хадгална. Бусдад хуваалцах боломжгүй, хэт эмзэг мэдээллийг хадгалах зориулалт бүхий "маш нууц" гэсэн хэсэг үүсгэнэ.

- МУ-ын Хувь хүний нууцын тухай, Архивын тухай хуулиудын дагуу байгууллагын бичиг хэргийн хамт кейс файлыг хадгална.

Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардал нь үйлчилгээ үзүүлэх байршил, гэр бүлийн орчинд, гэр бүлээс тусдаа орчинд үзүүлэхээс хамааран ялгаатай байна. Гэр бүлийн орчинд хүүхдэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх зардлын бүрэлдэхүүнд хүүхэд гэр бүлийн гишүүдтэй тулж ажилласан сургуулийн нийгмийн ажилтан (хамтарсан багийн гишүүд, нийгмийн ажилтан, хуульч, сэтгэл зүйч, эмч)-д олгох урамшуулал, тээвэр, холбон зуучлах, бичиг хэргийн болон шаардлагатай тохиолдолд баримтжуулах зардал багтсан.

Хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний кейсийг тоог “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ын 2-р хавсралтад заасан харгалзах нормативаар үржүүлж, хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний санхүүжилтийг олгоно. Мөн гэр бүлээс тусгаарлан хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний багцын зардлыг дунджаар 7 хоногийн зардал гэж тооцно.

2.3. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн дахин өртөхөөс сэргийлэх, хүчирхийлэлд өртөх эрсдэлтэй хүүхэд, гэр бүлд чиглэсэн зорилтот урьдчилан сэргийлэх шууд биш үйлчилгээг хэлнэ.

- Хүчирхийлэлд өртсөн хүүхдэд чиглэсэн эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллага, ажилтнууд чиглэсэн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
- Хүүхдийн хөгжлийн онцлог, ялгаатай байдалд тохирсон урьдчилан сэргийлэх төрөл бүрийн сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.
- Эцэг эх, иргэд, олон нийтийн ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, мэдлэг чадварыг хөгжүүлэх, хүчирхийллийн эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, дэмжих бүлэг зэрэг үйлчилгээ, үйл ажиллагааг багтаасан зорилтот урьдчилан сэргийлэх үйлчилгээг үзүүлнэ.
- Олон нийтэд чиглэсэн хүүхэдтэй зүй бус харилцах явдлаас сэргийлэх, хорт зуршлаас сэргийлэх хөтөлбөрүүд, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.
- Байгууллагын ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангах, тэднийг чадавхжуулах төрөл бүрийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

Сургуулийн үүрэг:

- Сургууль бол хүүхдийн амьдралын чухал тогтворжуулагч болдог. Хүүхдийн үйл ажиллагаа нь хүүхдийн өдөр тутмын хэвийн амьдралын эх сурвалж юм. Сурах үйл ажиллагаа нь тайван явагдах нь ихэд чухал.
- Гарз, уй гашууг даван туулахын тулд хүүхдүүд үе тэнгийнхэн болон итгэлтэй насанд хүрэгчидтэй өөрийн мэдрэмжийг хуваалцах боломж олгох хэлэлцүүлгийг ангид зохион байгуулаарай.
- Тэдний хариу үйлдэл хэвийн гэдгийг нь хүүхдүүдэд ойлгуулаарай. Багш нар хүүхдийн энэхүү хариу үйлдлийг ойлгож, түүний зовлон шаналлыг нимгэрүүлэхийн тулд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй.

- Өөрийн мэдрэмжийг илэрхийлэх, хуваалцахад нь хүүхдүүдэд туслах зорилгоор төрөл бүрийн үйл ажиллагаа зохион байгуулаарай. Энэхүү үйл явцад оролцож байгаа гэдэг баримтыг ухамсарлах. Зурах, яруу найраг, бичих, бүжиг, дуу, театр зэргийг ашиглаарай. Хүүхдүүд өөрсдөө зурагт хуудас, дуу, бүжиг, жүжигчилсэн тоглолт бэлтгэж орон нутгийн бусад гишүүдэд үзүүлж болно.
- Дуу хөгжим, спорт, урлаг зэрэг хичээлээс гадуурх үйл ажиллагаа зохион байгуулаарай.
- Асуудал бэрхшээлтэй хүүхдүүдийг илрүүлээрэй. Шаардлагатай тусламж, эмнэлгийн үйлчилгээ авахад нь сурагчид болон эцэг эхэд туслаарай. Эцэг эхтэй уулзалт зохион байгуулж, хүүхдүүдийн дунд зохиох арга хэмжээг хамт төлөвлөөрэй.
- Хүүхдийн зан үйлийн талаар эцэг эхэд мэдээлэл өгөөрэй.
- Хүүхдэд тулгарч болох асуудлуудын талаар эцэг эхэд мэдээлэл өгөөрэй.
- Хүүхдийн хүмүүжлийн эерэг аргын талаар мэдээлэл өгөөрэй.

Хүснэгт 9. Сургуульд түшиглэсэн хөтөлбөрүүд

Сургуульд түшиглэсэн сурлагын амжилтыг ахиулах, нийгмийн харилцааны чадвар хөгжүүлэх хөтөлбөр	Амьдрах ухаан ба нийгмийн харилцааны ур чадвар хөгжүүлэх хөтөлбөр
	Үе тэнгийн дарамт дээрэлхэлтээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр
	Сурлагын амжилтыг ахиулах хөтөлбөр
	Болзооны үеийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр
	Хичээл таслахгүй нөхцөлөөр өсвөр насныханд санхүүгийн урамшуулал олгох хөтөлбөр
	Үе тэнгийн зөвлөгчийн хөтөлбөр
	Хичээлээс гадуурх чөлөөт цагийн зохион байгуулалттай бусад арга хэмжээ
Эцэг эхийн боловсрол, бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр	Гэрээр зөвлөгөө өгөх хөтөлбөр Хүмүүжлийн эерэг аргыг хэрэглэх хөтөлбөр Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр

ХАВСРАЛТ

“ӨСВӨР НАСНЫ ХҮҮХДИЙН ТҮРЭМГИЙ ЗАН ҮЙЛИЙГ ЗАСАХ ХӨТӨЛБӨР” САЙН ТУРШЛАГА

Нийслэлийн боловсролын сургуулийн 17 дугаар сургуулийн нийгмийн ажилтан О.Сугараагийн өөрийн сургууль дээр хэрэгжүүлсэн сайн туршлага бүхий хөтөлбөрийг та бүхэнд танилцуулж байна. Нийгмийн ажилтан О.Сугараа энэхүү хөтөлбөрийг “Сэтгэл зүйн тренинг” номоос түүвэрлэн авч хүүхдийг нийгэмшүүлэх тоглоомын арга, гэрийн даалгавруудаар баяжуулан боловсруулан хэрэгжүүлснээр эерэг, нааштай үр дүн гарч эхлээд байгааг онцолсон юм.

- Хөтөлбөрийг өөрсдийн үйл ажиллагааны онцлогт тохируулан өөрчлөн баяжуулж хэрэглэх боломжтой.
- Түрэмгий зан үйл гаргадаг буюу үе тэнгийн дээрэлхэлт үйлддэг хүүхдийн зан үйлийг өөрчлөхийн тулд багагүй хугацаа шаардах нь ойлгомжтой бөгөөд эцэг эх, асран хамгаалагчидтай давхар ажиллах шаардлагатай ба ганцаарчилсан болон бүлгийн зөвлөгөө өгөх зэрэг арга техникийг цогцоор хэрэгжүүлэх нь үр дүнтэй байдаг байна.

Хөтөлбөрийн зорилго

- Түрэмгий зан үйл гаргадаг өсвөр насны хүүхдэд өөрийн сэтгэл зүйн байдлаа хянах, уур бухимдлаа зөвөөр илэрхийлэх, бусадтай зөв харилцах, өөрийгөө илэрхийлэх чадварыг дээшлүүлэх мөн өөрийгөө танин мэдэж, ирээдүйн зорилго мөрөөдлөө тодорхойлоход нь туслах.

Хугацаа

- 8 удаагийн сургалт (Нэг сарын хугацаанд буюу 7 хоногт 2 удаа, нэг удаад 60-90 минут орно)

Хамрах хүрээ

- 12-16 насны хүүхдүүд буюу ахлах дунд ангийн сурагчид (10-12 хүнтэй бүлэг үүсгэнэ)

Үйл явц

- Алхам 1. Тоглоом тоглох
- Алхам 2. Сургалтын үйл ажиллагаа
- Алхам 3. Гэрийн даалгавар

Ач холбогдол

- Өөрийгөө танин мэдэх, өөрийн болон бусдын мэдрэмж сэтгэл хөдлөлийг таних, оновчтой илэрхийлэхэд суралцах. Уур бухимдлаа зохицуулж түрэмгий зан үйл гаргахгүй байхад суралцана.

Сургалт 1.	Гар танилцдаг, гар муудалцдаг
Зорилго	Өөрийн бодлоо зөв илэрхийлэх, бусдыг ойлгох чадварыг хөгжүүлэх.
Хэрэглэгдэхүүн	Шаардахгүй
Хугацаа	20-25 минут
Заавар	Энэхүү сургалтыг хүүхдүүд хос хосоороо хуваагдан хийнэ. Хүүхдүүд хоорондоо сунгасан гарын зайтай, нүдээ аниатай чигээр бие биеийнхээ эсрэг харж сууна. Нүдээ аниад, өөд өөдөөсөө гараа өргөөд, нэг гараараа танилцаарай. Хөршөө сайн мэдэх гэж хичээгээрэй. Гараа буулгана уу. Ахиад гараа өргөөд хөршийнхөө гарыг олоорой. Та нарын гар хэрэлдэж байна. Гараа буулгаарай. Та нарын гар ахиад бие биеэ хайж байна. Та нарын гар ахиад бие биеэ хайж байна. Гар чинь эвлэрэхийг хүсэж байна. Та нарын гар эвлэрч байна. Гар чинь уучлалт гуйж байна, та найзаасаа салж байна. Сургалтын төгсгөлд сургалт хэрхэн явагдсаныг ярилцаж, сургалт гүйцэтгэж байх хооронд юу мэдрэгдсэн, юу хамгийн ихээр таалагдсан зэргийг ярилцана.
Эргэх холбоо	Харилцаанд зарим тохиолдолд нэгэндээ буулт хийж, сонсож байх нь яг л энэ сургалт дээр бид нэг нэгнийхээ мөрөнд зөөлөн хүрэхэд амар байсантай адил хөнгөн мэдрэмжийг төрүүлдэг гэдгийг санаж байгаарай.

Сургалт 2.	Шошго
Зорилго	Харилцагчаа эергээр мэдрэх чадварыг хөгжүүлэх.
Хэрэглэгдэхүүн	Жижиг цаас, үзэг
Хугацаа	10 минут
Заавар	Хүүхэд бүр цаасан дээр хүмүүсийг хэн юу гэж дуудвал дургүй байдгийг бичнэ. Ингээд цааснуудыг хурааж аваад хүүхэд бүрийн бие дээр 1 шошгыг наана. Хүнийг ингэж дуудах үед хүн юу мэдэрдэг, ямар санагддаг болохыг ярилцана. Дараа нь цаасыг салган авч урж хаяна.
Эргэх холбоо	Өөр дээрээ шошго наагаад явахад чамд ямар санагдсан бэ? Бас хүмүүс чамайг шошго дээрх нэрээр дуудах үед ямар мэдрэмж төрсөн бэ? Энгэртээ тэр шошгыг нааж явмаар байсан уу? эсвэл авч хаямаар санагдсан уу? зэрэг асуултад хүүхдүүдийн хариултыг авч хамтран ярилцана. Бид бүхэнд ангийн хүүхэд эсвэл заримдаа найзууд нэгнийгээ шоолох, нэр хоч өгөх тохиолдол их байдаг. Гэтэл энэ нь тухайн нэр хоч авч байгаа хүүхдэд таагүй мэдрэмж төрүүлдэг гэдгийг энэ сургалт ээс бүгдээрээ ойлгох болно.

Сургалт 3.	Мэдрэмжийн хавтас /Ганцаарчилсан болон бүлэг
Зорилго	<ul style="list-style-type: none"> • Өөрийгөө танин мэдэх чадварыг нэмэгдүүлэх • Өөрийн эерэг шинж чанарыг ярих • Тухайн зүйлийн талаар эерэг шинж чанаруудыг тодорхойлж, илэрхийлэх замаар өөрийгөө үнэлэх үнэлэмжийг дээшлүүлэх
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Хавтас; Маркерууд; Гялтгар гял цал ноорог цаас, цавуу, наалт зэрэг гар урлалын зүйл (заавал биш); Цаас; Үзэг эсвэл харандаа.
Хугацаа	25-30 минут
Заавар	Оролцогч эхлээд нэрээ бичээд дараа нь сайхан мэдрэмжийн хавтас гэж бичнэ. Жишээ нь: "Хулангийн сайхан мэдрэмжийн хавтас". Дараа нь хүүхэд өөрийн 10 эерэг шинж чанарыг цаасан дээр бичин дотор нь хийнэ. Үүний дараа хүүхдийн хамгийн түрүүнд хандаж болон гурван хүний жагсаалт гаргаж, өөрийнхөө тухай 5 эерэг зүйлийн жагсаалтыг багтаасан захиа бичнэ. Хүүхдийн эцэг эх, ах эгч, найз нөхөд, багш, нийгмийн ажилтан гэх мэт хүмүүс байж болно. Захиаг сайхан мэдрэмжийн хавтсанд хийнэ. Хүүхэд урьд өмнө нь ярьж байсан зүйлсээ эргэн дурсаж эсвэл хүмүүс түүний авьяас чадварыг таньж мэдсэн эсвэл түүнд талархаж байгаагаа илэрхийлсэн үеийг эргэн дурсаж, дараа нь эдгээр туршлагыг цаасан дээр буулгана, үүнийг ч хавтас дотор хийж болно.

Эргэх холбоо	Сургалт гүйцэтгэж байх явцад ямар бодол мэдрэмж төрсөн бэ? Амархан эсвэл хүндрэлтэй зүйлүүд байсан уу? гэх мэт асуултуудын хүрээнд ярилцаарай.
--------------	--

Сургалт 4.	Бөмбөг дэлбэрч байна /Ганцаарчилсан болон бүлэг
Зорилго	<ul style="list-style-type: none"> • Уур бухимдлаа илэрхийлэхэд тохирсон арга барил сурч, дадлагажуулж, хэрэгжүүлэх • Дотроо уураа барих нь хэрхэн асуудалд хүргэж болохыг тодорхойлох
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none"> • Бөмбөлөг /оролцогч хүн тус бүрт холр/; • Том хуудас /Хананд наах/; • Скоч; • Маркер; • Аюулгүй байдлын шилийг урьдчилж бэлтгэх
Хугацаа	25-30 минут
Заавар	<p>Оролцогч бүрд бөмбөлөг өгнө. /Бөмбөлөг дэлбэрэх үед гэмтэл бэртэл авахаас зайлсхийхийн тулд оролцогч бүрийг хамгаалалтын шил зүүхийг зөвлөж байна/. Дараа нь тэдэнд уурлаж байсан үеийнхээ талаар эргэн дурсахыг сануулах /тэдэнд ууртай нөхцөл байдлын талаар бодох ёстой гэж хэлээрэй, гэхдээ энэ үед тэд ууртай мэдрэмжийнхээ талаар ярихгүй/. Тэднээс ууртай мэдрэмжийг бөмбөлөгтөө хий гэж хэлнэ. Тэдэнд уурласан өөр нэг үеийг бодоод, тэр ууртай мэдрэмжийг бөмбөлөгтөө хийхийг сануулна. Тэдний бодож болох олон янзын нөхцөл байдлыг ашиглан ууртай мэдрэмжүүдээ бөмбөлөг рүү хүссэн хэмжээгээр нь хийлгэнэ. Эцэст нь бөмбөлөгүүд дэлбэрэх болно. Оролцогчдыг бөмбөлөг яагаад дэлбэрсэн гэж бодож байгаагаа хэлэхийг хүснэ.</p> <p>Дараах асуултуудыг асууна:</p> <ol style="list-style-type: none"> 1. Удаан хугацааны туршид бид сэтгэл хөдлөлөө мэдрэхгүй байх үед юу тохиолддог вэ? 2. Та эдгээр үеүдэд ямар арга хэмжээ авдаг вэ? <p>Оролцогч тус бүрд хоёр дахь бөмбөлөг өгч, уурласан үеэ дахин бодож, ууртай мэдрэмжүүдээ бөмбөлөгтөө хийсгэж эхлэхийг хүснэ. Бөмбөлгийг бага зэрэг агаараар дүүргэсний дараа оролцогчдыг зогсоод ууртай мэдрэмжийнхээ талаар ярилцана. Тэд уур бухимдлынхаа тухай ярихдаа бөмбөлөгүүдээс агаарыг бага багаар гаргаарай. Үүнийг хийсний дараа оролцогчдоос энэ удаад юу хийж байгааг нь, мөн юу өөр байгааг асууна. Харин сэтгэл зүйч тэдэнд "бөмбөлөг хэчнээн их агаараар дүүрсэн ч суллан тавихад дэлбэрэхгүй эргээд хэвэндээ орж болно гэх зэргээр зүйрлэн тайлбарлаж болно. Оролцогчдоос уур бухимдалтай байх үед өөрсдийгөө дэлбэрэхээс урьдчилан сэргийлэхийн тулд юу хийж болохыг асууна. Эдгээр асуудлыг шийдвэрлэх арга барилуудыг цаасан дээр бичүүлнэ. Хэрэв тэдэнд санаа бодлоо олоход бэрхшээлтэй байгаа бол дараах зүйлийг санал болгоорой.</p> <ol style="list-style-type: none"> 1. Өөрийн мэдрэмжийн талаар хэн нэгэнтэй ярилц; 2. 10-аас ухрааж аажмаар тоолно; 3. Тайвшруулах зорилготой амьсгалын дасгал хийх; 4. Сайхан дурсамжаа санах. <p>Жагсаалтыг гаргасны дараа оролцогчдоос дуртай даван туулах арга барилаа дээрээ саналаа өгөхийг хүснэ.</p>
Эргэх холбоо	Энэхүү сургалт нь өсвөр насныханд уур бухимдлаа буруу илэрхийлэх нь хэр хор уршигтай, ямар сөрөг үр дагаварт хүргэж болохыг ойлгоход туслах сонирхолтой арга юм. Энэ дасгал дээр бичсэн аргуудаа өдөр тутамдаа хэр их хэрэгжүүлэх боломжтой талаар нь оролцогчидтой ярилцана.

Сургалт 5.	Эерэг хандлагын хүч
Зорилго	<ul style="list-style-type: none"> Төвөгтэй нөхцөл байдлыг эерэг талаас нь харах арга замуудыг оролцогчдод ойлгуулах.
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none"> Баг болгонд нэг ширхэг шоо /эсвэл самбар, хатуу цаас, тодруулагч/
Хугацаа	25-30 минут
Заавар	<p>Дараах асуултуудыг хүүхдүүдээс асууна /нийт хүүхдүүдийн дунд эсвэл баг дотроо хийгээд, дараа нь нийт хүүхдүүдэд танилцуулах байдлаар хийж болно/</p> <ul style="list-style-type: none"> Эерэг хандлага гэж юу вэ? Хэрэв эерэг хандлагатай бол би ямар үйлдэл хийх вэ? Бусад хүмүүст миний эерэг хандлага хэрхэн нөлөөлөх вэ? Сөрөг хандлага гэж юу вэ? Хэрэв би сөрөг хандлагатай бол ямар үйлдэл хийх вэ? Бусад хүмүүст миний сөрөг хандлага хэрхэн нөлөөлөх вэ? <p>Эерэг хандлагаа хөгжүүлэх нь өөрөө өөртөө итгэж сурахаас эхэлнэ. Өөртөө итгэхийн тулд өөрийнхөө давуу талаа танин мэдэх хэрэгтэй. Оролцогчдыг дөрвөн баг болгоно. Доорх өгүүлбэрүүдийг бүх хүнд харагдахаар самбар дээр бичих эсвэл ширээ болгон дээр бичиж тавина /хүсвэл тухайн өгүүлбэр тус бүрийг зургаар илэрхийлж болно/. Оролцогч бүр 2-3 удаа шоог хаяж, шооны нүднүүдэд харгалзах дараах дутуу өгүүлбэрүүдийг гүйцээн хэлнэ:</p> <p>1 буувал: Би ... талархдаг.</p> <p>2 буувал: Бусад хүмүүс миний ... чадварыг магтдаг.</p> <p>3 буувал: Заримдаа хүмүүс миний ... чадварыг мэдээсэй гэж би хүсдэг.</p> <p>4 буувал: Би ... үед өөртөө үнэхээр сэтгэл хангалуун байдаг.</p> <p>5 буувал: Би өөрийн ... чадвараараа бахархдаг.</p> <p>6 буувал: Бусдыг баярлуулахын төлөө миний саяхан хийсэн зүйл бол ...</p> <p>Анхаарах зүйл: Хэрэв бүлгийн гишүүд бие биеэ маш сайн мэддэг бол тэдний эерэг зан чанарыг илэрхийлсэн чөлөөт асуултуудыг нэмэлтээр асууж болно.</p>
Эргэх холбоо	Шоо 6 буусан үед яагаад өгүүлбэрийг энэ дасгалд оруулсныг асууна. Хүн бусдад тусалснаараа өөрийнхөө талаар эерэг ойлголттой болдог гэдэг хариултыг тайлбарлан хэлнэ. Нэгэнт бид өөрсдийнхөө талаар эерэг төсөөлөлтэй болбол энэхүү эерэг хандлага нь бусдад илэрхий ажиглагдаж эхэлдэг. Бидний дотоод мэдрэмж эргэн тойрны хүмүүст хэрхэн нөлөөлж байдаг талаар оролцогчидтой чөлөөтэй ярилцана. Эерэг хандлага нь ажиллаж сурахад хийхэд хэрхэн нөлөөлдөг талаар мөн ярилцана.

Сургалт 6.	“Харилцааны хэлбэрүүд”
Зорилго	<ul style="list-style-type: none"> Харилцаанд биеийн хэлэмж, байрлал хэрхэн нөлөөлдгийг танин мэдэх
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none"> Шаардахгүй
Хугацаа	25-30 минут
Заавар	<p>Оролцогчдыг хос хосоор нь болгон хуваана. Хосоороо болсон оролцогчид эхлээд хэн нь ярих, хэн нь сонсох вэ? гэдгээ тохиролцоно.</p> <p>1-р хэсэг. Ярих оролцогчоо босгож зогсоон, сонсох оролцогч сууна. Ярилцах сэдэв нь өөрийн сонирхдог хобби, дуртай зүйлийнхээ талаар ярина.</p> <p>2-р хэсэг. Оролцогчид нуруу нуруугаа нийлүүлэн зогсоно. Өмнөх хэсэгт сонссон оролцогч харин одоо ярина. Ярилцах сэдэв нь хамгийн сүүлд тохиолдсон эсвэл “урьд өмнө нь тохиолдож байсан хөгжилтэй үйл явдлынхаа” талаар ярилцана.</p> <p>3-р хэсэг. Оролцогчид өөд өөдөөсөө 45 градусын байрлалтай болж сууна. Энэ удаад ээлжлэн ярих бөгөөд ярилцах сэдэв нь тантай ярилцахад “урьд өмнө нь тантай ярилцахад таатай сэтгэгдэл төрүүлж байсан тохиолдол”-ын тухай ярилцана. Тэр хүний тухай, нэр, нас, ямар сэдвээр ярилцсан нь тийм ч чухал биш. Хамгийн гол нь яагаад таатай сэтгэгдэл төрүүлсэн тухай ярилцах юм.</p>
Эргэх холбоо	Аль ярилцах хэлбэр таатай мэдрэмж төрүүлж байсан, ярилцахад ямар байсан тухай ярилцана. Бидний харилцаанд ярилцаж буй түвшин, биеийн хэлэмж чухал байдаг. Та бүгдийн ярилцсан харилцаанд нөлөөлж байгаа зүйлсийг бусадтай харилцахдаа анхаарч байгаарай.

Сургалт 7.	Тогтой хашаа
Зорилго	<ul style="list-style-type: none"> Сурагчдыг сэргээх, хөгжилтэй дасгал төдийгүй сэтгэл хөдлөлийн илэрхийллийг ажиглахад суралцана.
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none"> Шаардахгүй
Хугацаа	<ul style="list-style-type: none"> 40 минут
Заавар	<p>Одоо та бүхэн бүлгээрээ усан онгоцны багийн гишүүд болно. Усан онгоцонд ямар ямар хүмүүс байдаг вэ?</p> <p>Хүүхдүүд далайн дээрэмчний онгоц эсвэл хөлгийн ахмадын талаар бодох боломжийг олгох хэрэгтэй. Та бүхний онгоц живээд арай гэж хамгийн ойрхон арал руу сэлж гарч ирсэн. Маш их даарсан бас ядарсан байгаа. Арал дээр ширээ дүүрэн хоол халуун цай амттан та нарыг хүлээж байгаа хамгийн гол нь та бүхэн бүгдээрээ хамтдаа арлыг хамгаалж татсан тогтой хашааг давах ёстой. Нэг хүн үлдэх эсвэл тогтой хашаанд хүрэх л юм бол бүгд тогонд цохиулж үхэх тул хашаанд хүрэлгүйгээр давж гарах ёстой байгаа. Эдгээр зааврыг хүүхэд бүрд ойлгомжтойгоор тайлбарлан зааврыг дахин лавлаж асууж ойлголтыг нэгтгэсний дараагаар уяа татна. Хүүхдийн өндрөөс хамаарч хамгийн өндөр хүүхдийн бүсэлхийгээр хэмжээг авч утсыг татна.</p>
Эргэх холбоо	Дасгалыг хийх үед ямар байсан талаар оролцогч бүрээс асууж ярилцана.

Сургалт 8.	Миний газрын зураг /Ганцаарчилсан болон бүлэг
Зорилго	<ul style="list-style-type: none"> Хүүхдийн өөрийн үнэлэмж болон өөрийн бодит чадамж дээр тулгуурлан шийдвэр гаргах боломж, харилцах хүрээ, эерэг болон сөрөг хүрээлэл, ирээдүй төлөвлөгөө зэрэгт бодит зөвлөмж чиглэл өгөх.
Хэрэглэгдэхүүн	<ul style="list-style-type: none"> Цаас; Өнгийн харандаа
Хугацаа	<ul style="list-style-type: none"> 25 минут
Заавар	<p>Хүүхэд бүр өөрт байгаа цаасан дээрээ амьдралынхаа шидэт газрын зургийг хамгийн сайхнаар илэрхийлнэ. Энэ цаасан дээр чамайг төрөхөөс эхлээд том болох хүртэл чи ямар замаар явахыг хүсэж байна түүний яг л шидэт газрын зураг шиг зурахыг хичээгээрэй. Үүний дараагаар хүүхэд бүрийн газрын зурагтай танилцах ба ирээдүйд ямар мэргэжилтэй болох хэрхэн яаж амьдрах бусад газрын зургаас юугаараа ялгаатай талаар хамтдаа ярилцах болно.</p>
Эргэх холбоо	<ul style="list-style-type: none"> Сургалт гүйцэтгэж байх явцад ямар бодол мэдрэмж төрсөн бэ? Амархан эсвэл хүндрэлтэй зүйлүүд байсан уу? гэх мэт асуултуудын хүрээнд ярилцаарай.

Гэрийн даалгаврууд

Даалгавар 1	Дараагийн сургалт хүртэл өдөр бүрийн талархсан 3 зүйлээ тэмдэглэлийн дэвтэртээ оройдоо бичиж ирэх. Өөрөө хүсвэл талархсан зүйлсээ бусдадаа хуваалцаж ярих.
Даалгавар 2	Өдөр бүр талархлаа үргэлжлүүлэн бичих мөн гэр бүл ойр дотнын хүндээ талархсанаа илэрхийлэх.
Даалгавар 3	Мэдрэмжийн тэмдэглэл хөтлөх. Тэмдэглэлийн дэвтэр дээр мэдрэмжийн тэмдэглэл хөтлөн сэтгэл хөдлөлөө хянаж бичих. Уйтгар гуниг, уур бухимдлын үед бие махбодод хэрхэн хариу үйлдэл үзүүлж байгаагаа бичээрэй.
Даалгавар 4	Тэмдэглэлийн дэвтрээ ашиглан ууртай байгаа өөрийн мэдрэмжээ илэрхийлээрэй. Жишээлбэл: хэн нэгнийг орилж хашхирч үзэн ядаж байгаагаа хэлэхийн оронд тэмдэглэлээ ашиглан үүнийг илэрхийлэх.
Даалгавар 5	Өөрийгөө хэрхэн илэрхийлэхийг хүсэж байгаагаа бичээрэй. Өдөр бүр сэтгэл хөдлөлөө илүү сайн илэрхийлэхийн тулд нөхцөл байдал бүрийг хэрхэн зохицуулахаа бичээрэй. Дараа нь тухайн нөхцөл байдлыг төлөвлөсний дагуу бодитоор хэрэгжүүлж туршаарай.
Даалгавар 6	"Өнөөдөр би эерэг зүйлсэд анхаарлаа хандуулна" гэсэн уриаг хэрэгжүүлж, тэмдэглэлээ бичиж ирэх
Даалгавар 7	"Би (сайжруулахыг хүсэж буй нэг зуршил)-аа өнөөдөр сайжруулна" зорилго тавьж хэрэгжүүлэхэд анхаарч биеэ дайчлах. хүрсэн үр дүнгээ бусдад хуваалцах
Даалгавар 8	Өөртөө хэлэх 3-аас доошгүй урмын үгийг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж өөртөө чангаар уншиж өгөх. Сэтгэл санаагаар унасан үедээ өөртөө чангаар уншиж байх

Нийгэмшүүлэх дасгал тоглоомууд

Тоглоом 1. Өвдөг дээрээ суух

Тоглоомын зорилго: Бие биеэ мэдрэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх

Хугацаа: 5-10 минут

Заавар: Чиглүүлэгч оролцогчдыг битүү тойрог үүсгэн зогсооно. Оролцогчид баруун гар тийш эргэн өмнөх хүнийхээ мөрөн дээр хоёр гараа тавина. Мөрөн дээр гараа тавьсан хэвээр тойргийн төв рүү бүгд аажмаар жигд хөдлөн дотогш тойргийг хумьж өгнө. Ингэж тойрог хумигдсаны дараагаар оролцогчид бүгдээрээ нэгэн зэрэг ар арынхаа хүний өвдөг дээр аажмаар хагас сууна. Бүгд зэрэг сууж чадсан бол босох хөдөлгөөнийг хэд хэдэн удаа хийснээр дасгалыг дуусгана.

Өөр нэг хувилбар нь:

Тойргоор ар арынхаа хүний өвдөг дээр сууж, хагас тойрог үүсгэсэн бол тойрог нэгэн зэрэг аажмаар хагас суугаа байдлаар урагш хөндлөн явах үйлдлийг хийж болох юм. энэ нь бүлэгт хөгжилтэй байдлыг үүсгэх боломжтой.

Ач холбогдол: Бусдыг мэдрэх ойлгох, итгэлцэл бий болох, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлнэ.




Тоглоом 2: Надад итгэ**Тоглоомын зорилго:** Бусдын өмнө хүлээсэн үүргээ ухамсарлах, багийн гишүүдэд итгэх**Заавар:** Багийн гишүүнээ шалан дээр дээш харуулан хэвтүүлээд хамтын хүчээр дээш өргөнө. Өргүүлж буй хүн биеэ сул тавин, маш тайван тааламжтай сэтгэгдэлтэй байх ёстой бөгөөд нүдээ аних ёстой.**Хоёр хүн багаар тоглоход:** нэг нь нөгөөгийнхөө ард зогсох бөгөөд урд талд зогсож буй хүн хоёр гараа цээжин тушаа зөрүүлэн авч, булчингаа чангалан биеэ тэгшлэн зогсоно. Эхний хүн гэдрэгээ унахад арын хүн тосож барьж авна. Итгэлцэл аажмаар бий болохыг хамт эхлээд ойрхноос дараа нь арай холоос тосож авна.**Таван хүнтэй багаар тоглоход:** багийн нэг гишүүн сандал дээр биеэ чангалан зогсоно бусад нь хоёр хоёроороо сандлын хоёр талд гараа тосон зогсоно. Сандал дээрх хүн аажмаар хажуу тийш хазайн унахад бусад нь тосож авах ёстой. Ийнхүү унаж буй хүнийг аажмаар барьж авах бөгөөд унаж буй хүн нь цочихгүй байхыг хичээх ёстой. Аюулгүйн үүднээс шалан дээр зөөлөн матраас дэвсэх нь зүйтэй.**Наймаас арван хүнтэй багаар тоглоход:** багийн нэг гишүүнээ голдоо оруулан тойрч зогсоно. Голд зогсдог хүн нүдээ аньж булчингаа чангалан биеэ тэгш байлгах ёстой. Тойрч зогссон гишүүд түүнийг урагш хойш хажуу тийш түлхэхэд хэн нэг нь барьж аваад буцааж түлхэнэ. Түүнчлэн тойргийн голд байгаа хүнээ эргэлдүүлэх байдлаар түлхэж болно.**Тоглоом 3. Тохирох картыг ол**

Тоглоомын зорилго: оролцогчдыг хооронд нь танилцуулах

Хэрэглэх материал:

Нийтлэг хэрэглэдэг эерэг холбоо үг бичсэн тал цаас оролцогчдын тоогоор бэлдэнэ.

Хугацаа: 10-15 мин**Заавар:** Сургагч багш хүмүүсийн сайн мэдэх холбоо үгээс бүтсэн эерэг хэллэгийг тал цаасан дээр бичнэ. Жишээлбэл: "Баяр хүргэе", гэж нэг тал цаасан дээр, "Төрсөн өдрийн" гэж өөр нэг тал цаасан дээр бичнэ. (Тал цаас болон оролцогчдын тоо тэнцүү байх ёстой) Оролцогчид өөр өөрийн цаасны бичигтэй хэсгийг хагас нугалан урдаа барин өрөөн дотуур явж, бусад тоглогчийн барьж байгаа цаасны бичигтэй хэсэгт анхаарал хандуулан яриа өрнүүлэх замаар өөрийн бичигтэй цаасны үлдсэн тал хэсгийг олно. Ингэж хоёр цаасыг нийлүүлэн бичигдсэн утгыг бүрэн гаргасан оролцогчид тоглоомын дуусгана. Жишээ нь "Амжилт хүсье".**Ач холбогдол:** Оролцогчид хоорондоо танилцах боломж бүрдэн багийн уур амьсгал сайжирна.**Тоглоом 4. Харанхуй дахь гурвал****Тоглоомын зорилго:** Харалгүйгээр үйлдэл хийж сурах, бие биеэ таних стратегийг хамтран боловсруулах**Хэрэглэх материал:** Оролцогчдын нүдийг боох алчуур**Заавар:** Оролцогчдыг гурав гурваар нь багт хуваарилна. Хугацаа өгч багийн гишүүд бие биеэ таних стратеги боловсруулан тохиролцохыг зөвлөнө. Гэхдээ дуу гаргахгүйгээр бие биеэ олох ёстойг сануулна. Үүний дараа оролцогчдын нүдийг боож, тараан байрлуулна. Дохио өгмөгц багийн гишүүд өөр өөрийн хамтрагчаа олох болно. Ямар нэгэн дуу гаргахгүй. Багийн гишүүн бүрдсэн тохиолдолд "Окей" гэж хэлнэ.**Ач холбогдол:** Багаар хамтран ажиллаж сурах төдийгүй бусдын дунд биеэ зөв авч явж сурна.

Тоглоом 5. Бүлгийн хөгжил

Тоглоомын зорилго: Бусдыг сонсох, багаар хамтран ажиллаж сурах

Үргэлжлэх хугацаа: 5-15 минут

Заавар: Тоглоомын ахлагч оролцогчдыг дөрвөөс таван хүнтэй багт хуваагаад тоглоомын зааврыг танилцуулна. Багийн бүх гишүүн нэг сандал дээр байрлаж, дараах байрлалыг хэрхэн амжилттай гүйцэтгэх аргаа бодсон байх ёстой. Үүнд:

Хэрэв баг таван гишүүнтэй бол нийт 4 гар эсвэл хөл (3 хөл, 1 гар, 2 хөл, 2 гар гэх мэт) шаланд хүрсэн байх ёстой. Шаланд хүрсэн байрлалаар багууд дор хаяж 5 секунд тогтох ёстой.

Санамж: /хувилбар/

Дээрх дасгалыг дуусгаад дараах хоёр хувилбарыг хийлгэж болно. 5 хүнтэй багийнхан шалан дээр зөвхөн 3 тулах цэг, 4 хүнтэй баг зөвхөн 2 тулах цэг дээр тогтох. Аль болох олон хүн шаланд хүрэхгүйгээр сандал тогтсон баг хожно.

Тоглоом 6. Долоо дахь нь (Seven up)

Тоглоомын зорилго: Хүүхдүүдийн анхаарлыг төвлөрүүлж төлөвшүүлэх, багаар ажиллахыг идэвхжүүлэх

Заавар: Хүүхдүүдийг тойрог болгон зогсоогоод, хэн нэгэн оролцогч тоглоомыг эхлүүлнэ. Гэхдээ "Нэг" гэж хэлээд баруун, зүүн гарын аль аль нэгийг цээжиндээ авна. Тоолж байгаа хүн баруун гараа цээжиндээ авсан тохиолдолд зүүн гар талд зогсож байгаа хүнийг тоглоомд урьж байна гэсэн үг. Харин зүүн гараа цээжиндээ авсан тохиолдолд баруун гар талд байгаа хүүхдийг тоглоомд урина. Гараараа зааж буй чиглэлийг болон тоог сайтар анхааралтай ажиглаж, сандралгүй тайван оролцох бөгөөд аль болох хурдан хөдлөх ёстой. Анхааралтай ажиглаж чадаагүй буюу зангасан хүүхэд тоглоомоос хасагдана. Тоо долоо хүрэхэд найм дахь хүүхэд тоо хэлэлгүй аль нэг гараа толгой дээрээ авч "дээр" гэж хэлээд гараа заасан чиглэлийг хүн тоог "нэг"-ээс эхлүүлэн тоглоомыг үргэлжлүүлнэ. Хамгийн сүүлд үлдсэн хоёр хүүхэд ялагч болно.

Ач холбогдол: Хүүхдийн анхаарал тогтворжин, хурдан сэтгэж сурна. Түүнчлэн өөрийгөө илэрхийлж сурах төдийгүй хөгжөөнтэй байдлыг үүсгэнэ.

Тоглоом 7. Эргэлт

Тоглоомын зорилго: Бусдыг сонсож, хамтран ажиллаж, ойлголцох зэрэг багаар ажиллах чадварыг сайжруулах мөн өөрийгөө илэрхийлэх сурах

Заавар: Бүлгийн ахлагч оролцогчдыг тойрог болгон зогсооно. Бүгд тойрог болон зогсоод зүүн гараа тойргийн төвд тавина. Тэгээд баруун гараараа зүүн талынхаа хүний гарыг барина. Бүх гараа барилцсаны дараа эргэж гараа толгой дээгүүрээ давуулна. Ингэхэд тэд гараа зөрүүлэн гадагш харж зогссон байх болно. Дараа нь дахин эргэж дотогш харж зогсоно.

Ач холбогдол: Хүүхдүүд бие биеэ сонсож сурах болон хамтын ажиллагаа сайжирна.

эргэлт 1



эргэлт 2



Тоглоом 8. Том, жижиг бөмбөг

Тоглоомын зорилго: Хүүхдүүд том, жижиг бөмбөгийг ашиглаад хоорондоо танилцах ба өөрийгөө илэрхийлэх

Хэрэглэх материал: том, жижиг бөмбөг

Заавар: Оролцогчдыг тойрог болгон зогсооно. Тоглоомыг багш удирдан зохион байгуулна. Эхлээд жижиг бөмбөгийг авч оролцогчдын хэн нэгийг сонгон түүн рүү бөмбөгийг доороос дээш шидэж өгнө. Жижиг бөмбөгийг авсан оролцогч хоолойгоо нарийсган нэрээ хэлнэ. Багш дахин том бөмбөгийг авч доороос дээш шидэх хэлбэрээр түүрүүчийн оролцогч руу өгөхөд оролцогч хоолойгоо өргөсгөж нэрээ хэлэх гэх мэт дарааллаар бүх оролцогчийг нэрийг асууж танилцана.

Ач холбогдол:

Тоглогч бүрийн оролцоог нэмэгдүүлнэ. Өөрийгөө илэрхийлэх чадварт сургана. Багийн уур амьсгал сайжирна.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Боловсролын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2006
2. Хүүхдийн эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2016
3. Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2016
4. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхтгэл, УБ.,2017
5. Х.Баавгай, Хүүхдийн эрх, хамгаалалтай холбогдох нэр томьёо, ухагдахууны тайлбар толь, УБ.,2018
6. Жоан Е. Дюррант, Өдөр тутам хэрэглэх хүмүүжлийн эерэг арга, Хүүхдийг Ивээх Сан, УБ.,2007
7. Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Б.Мөнхжаргал, Нийгмийн ажлын үйлчилгээ: Боловсролын нийгмийн ажилтны гарын авлага, УБ.,2009
8. Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх зөвлөмж, УБ.,2020
9. Х.Өлзийтунгалаг, Б.Туяа, Хүүхэд хамгааллын холбон зуучлах үйлчилгээ: 24 агийн цэцэрлэгийн жишээн дээр, УБ.,2020
10. Х.Өлзийтунгалаг, Хүчирхийллийн хохирогчид нийгэм сэтгэл зүйн зөвлөгөө өгөх арга зүй, УБ.,2020
11. Х.Өлзийтунгалаг, М.Нямдорж, Э.Дуламсүрэн, Хамгааллын алхмууд: Кейс менежментийн нийтлэг арга зүй, УБ.,2020
12. Г.Түмэннаст, Т.Бүрэнжаргал, Н.Болдмаа, М.Батбаатар, Ц.Одгэрэл, Д.Оюунцэцэг, С.Түмэндэлгэр, Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал. Save the Children Japan, JICA, ХНХЯ, УБ.,2015
13. Г.Түмэннаст, Т.Бүрэнжаргал, Н.Болдмаа, М.Батбаатар, Ц.Одгэрэл, Д.Оюунцэцэг, С.Түмэндэлгэр, Хүүхэд хамгааллын хамтарсан багийн өнөөгийн байдал, ололт, амжилт, тулгамдаж буй асуудал. Save the Children Japan, JICA, ХНХЯ, ГБХЗХГ, УБ.,2018
14. Хэрэглээний сэтгэл судлалын хүрээлэн, Сэтгэл зүйн тренинг, УБ.,2021
15. Хүүхдийг ивээх сан, Нийгэмшүүлэх дасгал тоглоом, УБ.,2015

